

Төсөл 2025.05.12

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны..... дугаар сарын-ны өдрийн
.... дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”ХК-ИЙН
ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ**

(Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ... сарын .. өдрийн дугаар
тогтоолоор шинэчлэн батлав)

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл	4
ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ	4
Хоёрдугаар зүйл. Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл	4
Гуравдугаар зүйл. Биржид бүртгүүлэх хүсэлт гаргах	7
Дөрөвдүгээр зүйл. Үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр	7
ГУРАВ. ГАДААД УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ БҮРТГЭЛ	11
Тавдугаар зүйл. Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчид тавигдах нийтлэг шаардлага	11
Зургадугаар зүйл. Гадаад улсын үнэт цаас гаргагч Биржид бүртгүүлэх хүсэлт гаргах ..	12
Долдугаар зүйл. Хувьцаат компанийн тогтмол биелүүлэх зарим үүргээс чөлөөлөгдөх.	13
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ	14
Наймдугаар зүйл. Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах	14
Есдүгээр зүйл. Үнэт цаас бүртгүүлэх хэлбэр	15
ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ, ШАЛГУУР	16
Аравдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн шалгуур	16
Арван нэгдүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуур	17
Арван хоёрдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуур	18
Арван гуравдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн III ангиллын шалгуур	20
Арван дөрөвдүгээр зүйл. Өрийн хэрэгслийн шалгуур	23
Арван тавдугаар зүйл. Бүртгэлийн шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх	24
ЗУРГАА. ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА	26
Арван зургадугаар зүйл. Давуу эрхийн хувьцаа бүртгүүлэх хүсэлт гаргах, хянан шийдвэрлэх	26
Арван долдугаар зүйл. Давуу эрхийн хувьцаанд тавигдах шалгуур, шаардлага	26
Арван наймдугаар зүйл. Давуу эрхийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах	27
Арван есдүгээр зүйл. Давуу эрхийн хувьцааг бүртгэлээс хасах	27
ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	27
Хорьдугаар зүйл. Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах	27
Хорин нэгдүгээр зүйл. Нийтэд санал болгон нэмж үнэт цаас гаргах	30
Хорин хоёрдугаар зүйл. Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах	30
Хорин гуравдугаар зүйл. Үнэт цаасыг хуваах, нэгтгэх	31
Хорин дөрөвдүгээр зүйл. Бүртгэлийн ангилал тогтоох	31
ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ	32

Хорин тавдугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг.....	32
НАЙМ. БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС	33
Хорин зургаадугаар зүйл. Бүртгэлтэй компанийд үзүүлэх үйлчилгээний хөлс.....	33
ЕС. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ	35
Хорин долоодугаар зүйл. Үнэт цаасыг бүртгэлээс хасах	35
АРАВ. ХАРИУЦЛАГА	37
Хорин наймдугаар зүйл. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага	37
АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД	38
Хорин есдүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх	38
Гучдугаар зүйл. Хяналт шалгалт	38
Хавсралтууд:.....	39

DRAFT

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмаар үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн үнэт цаасны бүртгэл (цаашид “Биржийн бүртгэл” гэх)-д бүртгэх, бүртгэлийн ангилаал, шалгуурыг тогтоох, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Үнэт цаасыг бүртгүүлэхэд тавигдах шаардлага болон бүрдүүлэх баримт бичиг нь тухайн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны байдал, үнэт цаасыг гаргах хэлбэрээс хамаарч өөр байж болно.
- 1.3. Энэхүү журмыг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан үнэт цаас гаргагч, тэдгээрийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон андеррайтер, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин, үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн шинжээч зэрэг мэргэжлийн зөвлөхүүд дагаж мөрдөнө.
- 1.4. Биржийн бусад дүрэм, журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна.
- 1.5. Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд үнэт цаасаа Биржид хоёрдогч бүртгэлээр бүртгүүлж нийтэд арилжаалахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

Хоёрдугаар зүйл. Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл

- 2.1. Үнэт цаас гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд (цаашид “андеррайтер” гэх)-тэй гэрээ байгуулан бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийг хангана. Андеррайтер нь үнэт цаас гаргагч зөвшөөрсөн тохиолдолд нэг болон түүнээс дээш туслах андеррайтертай гэрээ байгуулж, үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагааг хамтран хэрэгжүүлж болно.
- 2.2. Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд бүртгэлтэй хууль, аудитын үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдтэй

гэрээ байгуулан, энэ журмын 2.6, 2.8-д заасан дүгнэлтийг гаргуулна. Түүнчлэн андеррайтер нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй этгээдтэй гэрээ байгуулан энэ журмын 2.7-д заасан дүгнэлт гаргуулж, нийтэд санал болгон гаргах хувьцааны үнийг тогтоож болно.

- 2.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьд, энэ журмын 2.6-2.8-д заасан дүгнэлт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн зөвлөгөө өгөх этгээд, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон аудитын үйлчилгээ эрхлэх этгээдээр гаргуулсан дүгнэлт байж болно.
- 2.4. Үнэт цаас гаргагч нь шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнээр үнэлэлт, дүгнэлт гаргуулж болно. Ийнхүү үнэлэлт, дүгнэлт гаргуулсан бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу холбогдох баримтыг хавсаргаж Биржид ирүүлнэ.
- 2.5. Хуулийн, аудитын, үнэлгээний, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргах компани, үндсэн андеррайтер нь үнэт цаас гаргагчтай болон хоорондоо холбогдох этгээд байхыг хориглоно. Өрийн хэрэгсэл (цаашид “Бонд” эсхүл “Өрийн хэрэгсэл” гэх) гаргагчийн хувьд Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 2.1.6 дахь заалтыг баримтална.
- 2.6. Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгүүлэхдээ Хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс дараах дүгнэлтүүдийг гаргуулсан байна.
Үүнд:
 - 2.6.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;
 - 2.6.2. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар;
 - 2.6.3. Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх;
 - 2.6.4. Бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
 - 2.6.5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу хийсэн эсэх;
 - 2.6.6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;
 - 2.6.7. Үнэт цаас, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
 - 2.6.8. Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч байгаа бол толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн

- үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч буюу эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;
- 2.6.9. Үнэт цаас гаргагч нь эдийн засгийн гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан, татвар, нийгмийн даатгалд болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөртэй эсэх;
- 2.6.10. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;
- 2.6.11. Үнэт цаас гаргагчтай сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бус ажилласан эсэх;
- 2.6.12. Уул уурхайн компанийн хувьд хайгуул хийх, ашиглах, олборлох эрх, тусгай зөвшөөрөлтэй холбоотой нөлөө үзүүлж болохуйц ямар нэг хуулийн зарга, хэрэг маргаан, эрх бүхий байгууллагын шийдвэр эсхүл бусад үйл ажиллагаа байгаа эсэх.
- 2.7. Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Хорооны журмаар тавигдсан нөхцөл, шаардлагыг хангаж, Хороонд бүртгэгдсэн этгээдээр компанийн хөрөнгийн үнэлгээг, өрийн хэрэгсэл гаргаж байгаа бол түүний эргэн төлөлтийг баталгаажуулах хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн байна. Хууль тогтоомжийг зөрчихөөргүй тохиолдолд Хорооны зөвшөөрлийн дагуу андеррайтер уг ажиллагааг хэрэгжүүлж болно.
- 2.8. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дараах асуудлаар дүгнэлт, тодорхойлох захидал гаргуулсан байна. Үүнд:
- 2.8.1. Танилцуулга бэлдэх үеийн сүүлийн 6 сарын доторх хугацааны санхүүгийн тайландауд аудит хийж, дүгнэлт гаргах;
- 2.8.2. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлagnalын олон улсын стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцэж байгаа эсэх;
- 2.8.3. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;
- 2.8.4. Үнэт цаас гаргагчтай сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бус ажилласан эсэх;
- 2.8.5. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг зөвшөөрч байгаа эсэх.
- 2.9. Энэ журмын 2.1, 2.2 болон 2.4-т заасан этгээдтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх хариуцлагыг тодорхой заасан байх бөгөөд үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх үүрэгтэй болохыг, үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дүгнэлт гаргахын тулд холбогдох баримт бичгийг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг бүрэн хүлээх тухайгаа тусгасан байна.
- 2.10. Үнэт цаас бүртгүүлэх бэлтгэл ажиллагааны үед гаргуулсан тусгай зөвшөөрөлтэй этгээдийн дүгнэлтүүдийн хамрах хугацаа, дүгнэлт гаргах хугацаанаас хамаарч мэдээллийн болон аливаа асуудлын зөрүү гарвал, тэр талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагыг Бирж үнэт цаас гаргагчид хүргүүлж болно.
- 2.11. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр тухайн жилд шалгарсан үнэт цаас гаргагч нь Биржид хувьцаа бүртгүүлэх хүсэлт гаргах

тохиолдолд хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулахыг шаардахгүй.

- 2.12. Үнэт цаас гаргагч нь андеррайтертай заавал гэрээ байгуулсан байх эсэх шаардлага нь Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасны дагуу тодорхойлогдоно.

Гуравдугаар зүйл. Биржид бүртгүүлэх хүсэлт гаргах

- 3.1. Үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл, үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтерийн Гүйцэтгэх захирал нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.
- 3.2. Үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:
 - 3.2.1 Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл (Маягт 1 эсхүл Маягт 2);
 - 3.2.2 Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт 3);
 - 3.2.3 Андеррайтерийн дүгнэлт, мэдэгдэл (Маягт 4);
 - 3.2.4 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 3.2.5 Үнэт цаасны танилцуулга;
 - 3.2.6 Энэ журмын 2.6-д заасан хууль зүйн дүгнэлт;
 - 3.2.7 Энэ журмын 2.7-д заасан үнэлгээний тайлан;
 - 3.2.8 Энэ журмын 2.8-д заасан аудитын дүгнэлт, тодорхойлох захидал;
 - 3.2.9 Хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн оролцсон бол энэ журмын 2.4-т заасны дагуу түүний гаргасан үнэлэлт, дүгнэлт;
 - 3.2.10 Энэ журмын 2.1, 2.2 болон 2.4-т заасан этгээдтэй байгуулсан гэрээний эх хувь;
 - 3.2.11 Өрийн хэрэгсэл гаргагчийн хувьд хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагчийн хооронд байгуулах Бондын гэрээ, шаардлагатай тохиолдолд андеррайтерийн гэрээ, барьцаа, баталгаа, батлан даалтын гэрээ;
 - 3.2.12 Энэ журмын 26.2.1-д заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт;
 - 3.2.13 Энэхүү журмын 2.11-т заасан этгээдийн хувьд Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын тодорхойлолт.
- 3.3. Засгийн газар Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасны үндсэн дээр үнэт цаасаа нийтэд санал болгон гаргахад энэ журмын 3.2.5-3.2.9-т заасан баримт бичгийг ирүүлэхгүй байж болох ба энэ тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуулийг баримтална.
- 3.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан баримт бичгийг ирүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл. Үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр

- 4.1. Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан болон Хороо, Биржээс тогтоосон бүхий л мэдээллийг агуулсан байна.

- 4.2. Танилцуулгад тусгагдах мэдээлэл нь үнэт цаас гаргагчийн тухай мэдээлэл, үнэт цаасны тухай мэдээлэл, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон этгээдийн тухай мэдээлэл гэсэн 3 хэсэгтэй байна.
- 4.3. Үнэт цаас гаргагчийн тухай мэдээлэл гэсэн хэсэгт дараах зүйлс тусгагдана.
Үүнд:
 - 4.3.1 Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх, гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын хувьд бүртгэгдсэн арилжаа эрхлэх байгууллагын тухай мэдээлэл;
 - 4.3.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр;
 - 4.3.3 Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, эрхэлж буй албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компаниудын талаарх мэдээлэл, хяналтын бүтэц, тэдгээрийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, холбогдох этгээдүүдийн тухай мэдээлэл;
 - 4.3.4 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
 - 4.3.5 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;
 - 4.3.6 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;
 - 4.3.7 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;
 - 4.3.8 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;
 - 4.3.9 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл;
 - 4.3.10 Компанийн эрх барих дээд байгууллага буюу Хувьцаа эзэмшигчдийн хурал эсхүл хуулиар зөвшөөрөгдсөн компанийн эрх бүхий этгээдийн баталсан ногдол ашгийн бодлого;
- 4.3.11 Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө;
- 4.3.12 Дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм;
- 4.3.13 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

- 4.4. Үнэт цаасны тухай мэдээлэл буюу шинээр гаргах үнэт цаас болон тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн талаарх мэдээлэл хэсэгт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 4.4.1. Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох болон арилжих нөхцөл, өрийн хэрэгслийн хувьд хугацаа, үндсэн төлбөр, хүү төлөх нөхцөл, журам;
 - 4.4.2. Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;
 - 4.4.3. Хувьцаанд хөрвөх үнэт цаас бол тухайн үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл, журам;
 - 4.4.4. Өрийн хэрэгслийн хувьд зээлжих зэрэглэл, эргэн төлөгдөх баталгаа, барьцаа эд хөрөнгийн тухай мэдээлэл, баталгаа, батлан даалт гаргагч этгээдийн мэдээлэл;
 - 4.4.5. Ногоон бонд гаргах эсхүл Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол энэ тухай мэдээлэл;
- 4.4.6. Анхдагч зах зээлд нийтэд санал болгох үйл ажиллагаа, арга, хэлбэрийн тухай мэдээлэл.
- 4.4.7. Ногоон бонд гаргах этгээд нь хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан бол уг дүгнэлтийн талаарх мэдээлэл.
- 4.5. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон этгээдийн тухай мэдээлэл хэсэгт дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 4.5.1. Тухайн үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухай мэдээлэл;
 - 4.5.2. Тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл;
 - 4.5.3. Ногоон бонд гаргах этгээд нь хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан бол уг этгээдийн тухай мэдээлэл;
- 4.5.4. Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл.
- 4.6. Танилцуулгад дараах шаардлага тавигдана. Үүнд:
 - 4.6.1. “Үнэт цаасыг “Монголын хөрөнгийн бирж” ХК болон Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.” гэснийг танилцуулгын эхний хуудсанд тодор бичсэн байна.
 - 4.6.2. Үнэт цаасны танилцуулгыг журмын 3.1-т заасны дагуу баталгаажуулсан байх бөгөөд “Биржид ирүүлж байгаа танилцуулга нь Хороонд хүргүүлж

байгаа танилцуулгатай адил, аливаа зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй талаар баталгаа гаргасан байна;

- 4.6.3. Үнэт цаасны танилцуулга нь 400-аас илүүгүй хуудастай байх бөгөөд үдэж, хавтасласан, товьёг хийсэн баримтын хэлбэртэй байна;
 - 4.6.4. Үнэт цаасны танилцуулгын бүх хуудсыг нэг бүрчлэн дугаарлаж, үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал, андеррайтерийн Гүйцэтгэх захирал нар хуудас бүрийн баруун доод буланд гарын үсэг зурж, гарын үсэг зурсан огноог бичсэн байна.
 - 4.7. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд үнэт цаасны танилцуулгыг гадаад хэлээр боловсруулсан бол Монгол хэлэнд хөрвүүлсэн баталгаат орчуулгыг хавсаргана.
 - 4.8. Үнэт цаасны танилцуулгад дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:
 - 4.8.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 4.8.2. Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, үнэт цаас гаргахтай холбогдон дүрэмд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, дүрмийн төсөл;
 - 4.8.3. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн хувь;
 - 4.8.4. Хэрэв зах зээл үүсгэгчтэй үнэт цаасны хөрвөх чадварыг хангах тухай гэрээ байгуулсан бол түүний хувь;
 - 4.8.5. Үнэт цаас хариуцсан, Биржтэй харилцах этгээдийн танилцуулга, холбоо барих хаяг;
 - 4.8.6. Энэ журмын 2.6, 2.7 болон 2.8 -д заасан тайлан, дүгнэлт.
 - 4.8.7. Уул уурхайн ашиглалтын, хайгуулын компаниуд нь 4.8.1-4.8.6-д заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг үнэт цаасны танилцуулгад хавсаргана. Үүнд:
 - 4.8.7.1. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн бэлтгэж, баталгаажуулсан техникийн тайлан, шинжээчийн санал, дүгнэлт, уг тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл;
 - 4.8.7.2. Хэтийн төлөв, хайгуул, олборлолт, газар ашиглалт болон олборлох, ашиглах, үйлдвэрлэх эрхийн зэрэг, чанар.
 - 4.8.8. Үнэт цаас гаргагч нь тусгай зөвшөөрөлтэй тохиолдолд хүчинтэй тусгай зөвшөөрлийн хуулбар;
 - 4.8.9. Үнэт цаас гаргагч ба уг үнэт цаасыг гаргах ажиллагаанд оролцогч этгээд нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх шаардлагатай этгээд бол, Хорооноос олгосон хүчинтэй зөвшөөрөл, Хороонд бүртгэгдсэн тухай шийдвэрийн хуулбар;
 - 4.8.9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийг нотлох бусад баримт.
- 4.9. Олон улсын санхүүгийн байгууллага нь бонд гаргахдаа бондын танилцуулгыг бэлтгэсэн бол байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд, андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан бол уг компанийн гүйцэтгэх захирал тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.
 - 4.10. Аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргах үнэт цаасны хувьд Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан шаардлагын дагуу үнэт цаасны

танилцуулга эсхүл албан мэдэгдэл бэлтгэх ба уг журмаар тогтоосон бусад нөхцөл, шаардлагыг хангасан болохыг нотлох баримтыг Биржид ирүүлнэ.

- 4.11. Үнэт цаас гаргагч энэ журамд заасны дагуу өргөдөл, танилцуулга, баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлж хэвлэмэл хэлбэрээр хоёроос доошгүй эх хувийг Биржид хүргүүлэх ба Биржийн цахим хуудаст байршуулах баримтыг шаардлагын дагуу цахим хэлбэрээр Биржид хүргүүлнэ.
- 4.12. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгыг Биржид хүргүүлснээс хойш, эсхүл Биржийн бүртгэлд бүртгэх шийдвэр гарч, анхдагч зах зээлд байршуулах хүртэл хугацаанд дараах өөрчлөлт орсон тохиолдолд, үнэт цаасны танилцуулгад орсон өөрчлөлт, нэмэлт мэдээллийг үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал, андеррайтерийн гарын үсгээр баталгаажуулан Биржид хүргүүлж бүртгүүлэх үүрэгтэй. Үүнд:
 - 4.12.1. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн агуулгад материаллаг өөрчлөлт орсон;
 - 4.12.2. Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэнснээс хойш компанийн үйл ажиллагаанд болон түүний үйл ажиллагаа явуулж байгаа зах зээлд хөрөнгө оруулагчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон.
- 4.13. Хорооноос шаардаагүй тохиолдолд үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн Аравдугаар зүйлийн 10.15 дахь заалтыг үндэслэн үнэт цаасны танилцуулга бэлтгэхгүй байж болно.

ГУРАВ. ГАДААД УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ БҮРТГЭЛ

Тавдугаар зүйл. Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчид тавигдах нийтлэг шаардлага

- 5.1. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч ("гадаад улсын үнэт цаас гаргагч" гэх) нь Хорооны баталсан "Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын жагсаалт"-д хамаарах гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн бөгөөд тухайн бүртгэл нь хүчин төгөлдөр байна.
- 5.2. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь Монгол Улсад үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбогдуулан тухайн үнэт цаас гаргагчийг төлөөлөн мэдэгдэл хүлээн авах, Бирж болон хувьцаа эзэмшигчидтэй харилцах эрх бүхий этгээдийг Монгол Улс дахь эрх бүхий төлөөлөгчөөр томилон ажиллуулах үүрэгтэй.
- 5.3. Энэ журмын 5.2-т заасан этгээдийг томилох болон эрхийг нь дуусгавар болгох бүртээ дэлгэрэнгүй мэдээллийг Биржид хүргүүлнэ. Үүнд:
 - 5.3.1. Мэдэгдэл хүлээн авах байнгын хаяг;
 - 5.3.2. Хэрэв мэдэгдэл хүлээн авах хаяг нь тухайн этгээдийн ажлын байрнаас өөр эсвэл тухайлсан ажлын байр байхгүй тохиолдолд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг;
 - 5.3.3. Холбоо барих дугаар, цахим шуудангийн хаяг, факсын дугаар;
 - 5.3.4. Энэ журмын 5.3.1-5.3.3 дахь заалтад заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай.

- 5.4. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь энэхүү журам, Биржээс баталсан бусад дүрэм, журам, зааварт заасан тодорхой шаардлагаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.5. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь анхдагч бүртгэл хийлгэсэн арилжаа эрхлэх байгууллагын зохих дүрэм, журмыг зөрчсөн байдал нь Монгол Улс дахь бүртгэл болон үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх талаар Бирж нь дүгнэлт, шийдвэр гаргах эрхтэй байна.

Зургадугаар зүйл. Гадаад улсын үнэт цаас гаргагч Биржид бүртгүүлэх хүсэлт гаргах

- 6.1. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь Монгол Улсад гаргах үнэт цаасаа Хорооны бүртгэлд болон Биржийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг нэгэн зэрэг гаргаж болох бөгөөд Бирж нь бүртгэлд бүртгэх шийдвэр гаргаснаас хойш ажлын 2 өдрийн дотор тухайн шийдвэрийг Хороонд хүргүүлнэ.
 - 6.2. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг Биржид хүргүүлэхдээ дараах баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:
 - 6.2.1 Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл (Маягт 1);
 - 6.2.2 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.3 дахь хэсэг болон энэ журмын 6.4-т заасан шаардлагын дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга;
 - 6.2.3 Гадаад улсын зохицуулах байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулга, нэмэлт танилцуулга болон бусад холбогдох хавсралтын Англи хэл дээрх хуулбар, тэдгээрийн товч танилцуулгыг Монгол хэл рүү орчуулсан хувь;
 - 6.2.4 Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт 3);
 - 6.2.5 Андеррайтерийн мэдэгдэл (Маягт 4);
 - 6.2.6 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 6.2.7 Эрх бүхий дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн болон аудитын байгууллагын дүгнэлт;
 - 6.2.8 Энэ журмын 5.2-т заасан эрх бүхий төлөөлөгчийг томилсон мэдэгдэл болон тэдгээрийн мэдээлэл;
 - 6.2.9 Энэ журмын 26.2.1-д заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 6.3. Биржийн бүртгэл нь Гадаад улсын үнэт цаас гаргагчийн Монгол Улсад шинээр гаргаж буй үнэт цаас болон өмнө нь гаргасан тухайн төрлийн бүх үнэт цаасанд хамаарна.
 - 6.4. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулга нь Хорооны "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам"-д нийцсэн байна.
 - 6.5. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтэд тухайн үнэт цаас гаргагчийн ТУЗ буюу түүнтэй адилтгах удирдлагын багийн эрх бүхий 2 албан тушаалтан эсвэл томилогдсон эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
 - 6.6. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь Монгол Улсад нийтэд санал болгон шинээр нэмж үнэт цаас гаргахад энэ журмын 3 дугаар бүлэг, хаалттай хүрээнд нэмж

үнэт цаас гаргахад энэ журмын 6 дугаар бүлэгт заасан зохицуулалтыг баримтална.

- 6.7. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн анх бүртгүүлсэн гадаад улсын зах зээлд тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргах, опцион хэрэгжүүлэх замаар үнэт цаасны бүрдүүлбэрт нь өөрчлөлт орох тохиолдолд үнэт цаас гаргагч болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн албан бичиг, мэдэгдэл, Хорооны даргын тушаалд үндэслэн Биржийн бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 6.8. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн гадаад улсын зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд энэ журмын 6.7-д зааснаас бусад хэлбэрээр өөрчлөлт орох тохиолдолд үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдэгдэл, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай Хорооны шийдвэр, баримт бичгийг үндэслэн Биржийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

Долдугаар зүйл. Хувьцаат компанийн тогтмол биелүүлэх зарим үүргээс чөлөөлөгдөх

- 7.1. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь Хороо болон Биржид аливаа тайлан болон мэдээлэл хүргэхдээ үнэт цаасаа анх бүртгүүлсэн улс, арилжаа эрхлэх байгууллагын хууль, журмыг дагаж мөрдэж болох ба ингэхдээ анхдагч бүртгэл хийлгэсэн байгууллагад хүргүүлж буй бүхий л мэдээллийг Биржид тогтмол, Монгол хэл дээрх орчуулгын хамт (шаардлагатай тохиолдолд Монгол хэл дээрх товч танилцуулга байж болно) нэгэн зэрэг ирүүлнэ. Бирж болон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын байршилаас шалтгаалан цагийн зөрүү үүссэн тохиолдолд, Биржид мэдээллийг нэгэн зэрэг цахим шуудангаар ирүүлснээр гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад түрүүлж мэдээллээ нийтэлж болно. Бирж нь хүлээн авсан мэдээллийг дараагийн ажлын өдрийн эхэнд олон нийтэд мэдээлнэ.
- 7.2. Бирж нь гадаад улсын үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй үнэт цаасны зохицуулах газар, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага болон харьяалах улсын төрийн байгууллагаас тус үнэт цаас гаргагчаар дамжуулан эсхүл шууд хандан мэдээлэл хүсэх эрхтэй.
- 7.3. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаас нь Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргах хүсэлтэд дурдсаны дагуу Монгол Улсын хууль тогтоомжид заасан дараах үүргээс чөлөөлөгдөж болох ба өөрийн харьяалах улсын эсвэл анхдагч бүртгэл хийлгэсэн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх эрхтэй байна. Үүнд:
 - 7.3.1. ТУЗ, түүний бүтэц, хараат бус гишүүдийн тоо, гүйцэтгэх удирдлага зэрэг компанийн бүтэц, удирдлагын тогтолцоо, түүний үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт;
 - 7.3.2. Санхүүгийн тайлан болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэлтэй холбоотой зохицуулалт;
 - 7.3.3. Хувьцаа эргүүлэн худалдан авах, тэргүүн ээлжид худалдан авах болон худалдахтай холбоотой хязгаарлалт бүхий зохицуулалт;
 - 7.3.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт;
 - 7.3.5. Бүртгэлтэй байх хугацаанд нийтэд мэдээлэл хүргэхтэй холбоотой зохицуулалт;

- 7.3.6. Их дүнтэй гүйлгээ болон хэлцлийн хэмжээг нарийвчлан заасан зохицуулалт;
- 7.3.7. Үнэт цаас гаргагч хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахтай холбоотой зохицуулалт;
- 7.3.8. Энэхүү журмын 5.4-т заасан хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсэн асуудалтай холбоотой зохицуулалт.

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

Наймдугаар зүйл. Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах

- 8.1. Бирж нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өргөдөл, энэ журмаар тогтоосон баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор хянаж, бүртгэлийн шалгалт хийнэ.
- 8.2. Энэ журмын 2.11-д заасан үнэт цаас гаргагч болон Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.3-д заасан этгээдийн шаардлага хангасан, бүрдэл бүрэн хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.
- 8.3. Хянан шалгах хугацааг өргөдөл гаргагчийн баримт материал нь зохих шаардлагыг хангаж, бүрдэл бүрэн болсон өдрөөс эхлэн тооцох ба шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тухайн компанийн удирдлагаас үнэт цаас, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар тодруулга, нэмэлт баримт бичиг гаргуулах, үнэт цаас гаргагчтай уулзалт ярилцлага хийх байдлаар баримт нотолгоог гаргуулан авч болно.
- 8.4. Бирж нь үнэт цаас гаргагч болон түүний нийтэд санал болгох үнэт цаас нь бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангаж байгаа эсэх талаар хийгдсэн шалгалтын тайланда үндэслэн үнэт цаасыг бүртгэх эсэх асуудлыг Бүртгэлийн хороо (байхгүй бол Захирлын зөвлөлийн хурал)-гоор хэлэлцэн Гүйцэтгэх захирал тушаалаар баталгаажуулах ба шийдвэрийн хувийг Хороо болон үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.
- 8.5. Энэ журмын 8.4-т заасан шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг, аудитын болон үнэлгээний зэрэг бусад хөндлөнгийн байгууллага, мэргэжилтний дүгнэлт гаргуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр сунгана.
- 8.6. Бирж нь үнэт цаасыг бүртгэсний үндсэн дээр үнэт цаас гаргагчтай "Бүртгэлийн гэрээ" байгуулж, үнэт цаасыг бүртгэх бөгөөд бүртгэсэн тухай Гүйцэтгэх захирлын тушаалын хуулбарыг энэ журмын хавсралт 6-д заасан мэдэгдлийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.
- 8.7. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан хувьцаанд үсгэн код, үнэт цаасны нэр олгож бүртгэнэ.
- 8.8. Хувьцааны үсгэн код нь тухайн үнэт цаас гаргагч компанийн нэрийг илэрхийлэх 3-аас доошгүй 4-өөс илүүгүй латин үсгээр тэмдэглэгдэнэ.
- 8.9. Өрийн хэрэгслийг үнэт цаасны нэрээр бүртгэх ба үүнд өрийн хэрэгслийн хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөгдөх хугацаа зэргийг тусгах бөгөөд бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тохиолдолд транч болгонд ялгах тэмдэглэгээ хийнэ.
- 8.10. Үнэт цаасны код, нэрийг давхардуулж үл болно.

8.11. Дараах тохиолдолд үнэт цаасыг бүртгэхээс татгалзана. Үүнд:

- 8.11.1. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг энэ журам болон Хорооноос тогтоосон журмын дагуу гаргаагүй;
 - 8.11.2. Үнэт цаас гаргагч эсхүл түүний гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ журмаар тогтоосон шалгуур, шаардлага болон Биржээс тогтоосон тухайн ангиллын шалгуурыг хангагүй;
 - 8.11.3. Шаардлагатай мэдээллийг хүсэлтэд тусгаагүй эсхүл дутуу тусгасан, тогтоосон хугацаанд нэмэлт баримт бичгийг ирүүлээгүй;
 - 8.11.4. Худал, төөрөгдүүлсэн, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан;
 - 8.11.5. Шаардлагатай нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй;
 - 8.11.6. Энэ журамд заасны дагуу гаргасан аудитын, үнэлгээний болон хуулийн дүгнэлтэд үндэслэн тухайн үнэт цаасыг бүртгэх нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлнө гэж Бирж үзсэн;
 - 8.11.7. Үнэт цаас гаргагч нь Биржид үнэт цаасаа бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл гаргаснаас хойш З сарын хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд бүртгүүлэхтэй холбоотой шаардлагыг бүрэн биелүүлээгүй.
- 8.12. Үнэт цаас гаргагч нь Биржид ирүүлсэн танилцуулга, түүнд хавсаргасан бүх баримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг бүртгүүлэхтэй холбоотой бүх баримт бичгийг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд өөр дээрээ хадгална.
- 8.13. Бирж нь үнэт цаасыг тодорхой үйл явдлаас шалтгаалах болзол тавьж бүртгэхийг хориглоно.
- 8.14. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Биржийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд холбогдох журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

Есдүгээр зүйл. Үнэт цаас бүртгүүлэх хэлбэр

9.1. Үнэт цаасыг дараах байдлаар бүртгүүлж болно. Үүнд:

- 9.1.1. Өөрийн эзэмшлийн хувийг санал болгох: Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь компанийн нийт гаргасан хувьцааны 5 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний өөрийн эзэмшлийн хувьцаагаа анхдагч зах зээлд худалдаж болно. Энэ тохиолдолд компани нь нэмэлт хөрөнгө оруулалт татахгүй.
- 9.1.2. Хаалттай хүрээнд санал болгох: Тодорхой этгээдэд хаалттай хүрээнд нэр заан эзэмшүүлж болно.
- 9.1.3. Тэргүүн ээлжид давуу эрхтэйгээр санал болгох:
 - 9.1.3.1. Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 25.6, 34.2 болон 38 дугаар зүйлд зааснаар одоогийн хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжид давуу эрхтэйгээр санал болгох тохиолдолд андеррайтераар дамжуулна.
 - 9.1.3.2. Хэрэв тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй гаргаж байгаа хувьцааны үнийн дүн нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө эсхүл зах зээлийн үнэлгээг 50 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлж байвал дараах нөхцөлийг хангах шаардлагатай.

- 9.1.3.2.1. Тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй үнэт цаас гаргах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байх;
 - 9.1.3.2.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэн, тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлэх эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх арга зам, уг эрхээ эдлэх хугацаа, энэ хугацаанд эрхээ хэрэгжүүлээгүйгээс гарах үр дагаврын талаар танилцуулга, мэдээлэл, журамд тодорхой тусгасан байх.
 - 9.1.4. Нээлттэй хүрээнд санал болгох: Нээлттэй хүрээнд санал болгож буй үнэт цаасыг одоогийн эзэмшиж байгаа хувь хэмжээнээс үл хамааран аль ч этгээд худалдаж авах боломжтой бөгөөд андеррайтертай гэрээ байгуулсан байх;
 - 9.1.5. Хуримтлагдсан ашиг, ногдол ашиг, өр төлбөр зэргийг хувьцаанд шилжүүлэх замаар хувьцаа санал болгох;
 - 9.1.6. Давуу эрхийн хувьцаа санал болгох: Хууль тогтоомжийн хүрээнд компани нь давуу эрхийн хувьцааг санал болгон арилжиж болох ба давуу эрхийн хувьцааны бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг хуульд өөрөөр заагаагүй бол энэхүү журмаар тодорхойлно.
- 9.2. Энэ журмын 9.1-т заасан үнэт цаас бүртгүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, үнэт цаасны танилцуулга, хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээлэл, холбогдох журам, түүнийг баталсан шийдвэр гарсан байна.
 - 9.3. Засгийн газраас гаргасан болон Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан өрийн хэрэгслийн бүртгэлийг Сангийн яамны зөвшөөрлийн дагуу Биржид бүртгэн арилжиж болно.
 - 9.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэл (бонд) ба олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг энэхүү журам болон Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ийг баримтлан бүртгэнэ.
 - 9.5. Олон улсын санхүүгийн байгууллагаас бусад гадаад улсын үнэт цаас гаргагчийн гаргасан өрийн хэрэгсэл, гадаадын биржид урьд нь гаргасан өрийн хэрэгсэл зэрэгт энэ журам хамаarahгүй бөгөөд гадаад валютаар гаргах өрийн хэрэгслийг эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу Биржид бүртгүүлэн арилжаалж болно.

ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ, ШАЛГУУР

Аравдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн шалгуур

- 10.1. Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгүүлэхдээ болон бүртгэлтэй байх хугацаанд энэ журамд заасан шалгуурыг хангаж ажиллана.
- 10.2. Шинээр ба нэмж үнэт цаас бүртгүүлэх, нэгдэж, нийлэх, хуваах, тусгаарлах замаар үнэт цаас болон компани бүртгүүлэхдээ энэ бүлэгт заасан тухайн ангиллын шалгуурыг хангасан байна.
- 10.3. Биржийн бүртгэлд хувьцааг тус бүрийн онцлог шалгуур бүхий “I”, “II”, “III” гэсэн гурван ангиллаар бүртгэнэ.
- 10.4. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл нь үнэт цаас гаргагчийн гаргасан тухайн төрлийн бүх үнэт цаасанд хамаарна.

- 10.5. Үнэт цаас гаргагч нь ангилал тус бүрд тогтоосон шалгуураас гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 10.5.1. Үнэт цаас гаргагч болон түүний эцсийн өмчлөгч нь их хэмжээний татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх;
 - 10.5.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь бүхэлдээ эсхүл дийлэнх хэсэг нь мөнгөн хөрөнгө болон богино хугацаат үнэт цааснаас бүрдээгүй байх. Энэ шаардлагыг компанийн үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан хөнгөлж болно.
 - 10.5.3. Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх хамгийн сүүлийн санхүүгийн жилийн үеэр санхүүгийн тайлагналын хугацаагаа өөрчлөхгүй байх;
 - 10.5.4. Үнэт цаас гаргагчийн биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх санхүүгийн тайлан нь хамгийн сүүлийн санхүүгийн жилийн аудитаар баталгаажсан тайлан байх ба тайлангаас хойш 6 сар өнгөрсөн тохиолдолд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн (IFRS) санхүүгийн тайланг өргөдөл гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо болон ТУЗ-өөр баталгаажуулсан мэдэгдэл;
 - 10.5.5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрддөг байх;
 - 10.5.6. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь үнэнч шударга, ёс зүйтэй байх;
 - 10.5.7. Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх;
 - 10.5.8. Компанийн удирдлага болон хяналтын багц эзэмшигчид бүртгэгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд нийт зах зээлийн үнэлгээний 15-аас доош хувьтай тэнцэх хэмжээний үнэт цаасыг дотоодын зах зээлд санал болгосон тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

Арван нэгдүгээр зүйл. Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуур

- 11.1 Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 11.1.1. Өргөдөл гаргахаас өмнө 3-аас доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
 - 11.1.2. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Сүүлийн жилийн аудитын тайлангийн дүгнэлт нь “Зөрчилгүй санал дүгнэлт”, өмнөх 2 жилийн хувьд “Зөрчилгүй санал дүгнэлт” эсхүл “Хязгаарлалттай санал дүгнэлт” байна. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд, гадаад улсын биржид мөрддөг санхүүгийн тайлагналын аливаа стандартын дагуу тайлагнахыг зөвшөөрөх ба Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS) болон тайланд ашигласан стандартын дагуу санхүүгийн үзүүлэлтэд орох материаллаг зөрүүгийн тухай тайлбар гаргана;
 - 11.1.3. Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд эсхүл сүүлийн 3 жилийн дунджаар жилд 10 000 000 000 (арван тэрбум) төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой, эсхүл 3 000 000 000 (гурван тэрбум) төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажилласан байх ба орлого, зардал,

- цэвэр ашгийн тооцоололд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлого, зардал, онцгой шинжтэй олз, гарзыг тооцохгүй;
- 11.1.4. Сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх ба сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд өөрчлөлт ороогүй бол давуу тал болно;
- 11.1.5. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх;
- 11.2. Уул уурхайн компани нь журмын 11.1.1-11.1.5-д заасан шалгуураас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 11.2.1. Хөндлөнгийн мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн тооцоопсон 10 жилээс доошгүй хугацаанд олборлох баттай эсхүл магадлалтай ашигт малтмалын ордын нөөцтэй байх;
- 11.2.2. Бизнесийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх ажлын капитал (эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн)-тай байх;
- 11.2.3. Хөрөнгийн бүтцийн 30-аас доошгүй хувь нь өөрийн хөрөнгө байх;
- 11.2.4. 5 000 000 000 (таван тэрбум) төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр биет хөрөнгө (нийт хөрөнгөөс нийт өр төлбөр, давуу эрхийн хувьцаа, биет бус хөрөнгийг хассан дүн)-тэй байх.
- 11.3. Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх/ бүртгүүлсэн үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна. Үүнд:
- 11.3.1. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 30 000 000 000 (гучин тэрбум) төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно;
- 11.3.2. Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилийн арилжигдсан үнийн дүн нь Биржээр арилжаалагдсан хувьцааны багцын арилжаанаас бусад нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь байх. Хоёрдогч бүртгэл хийлгэх гадаад улсын үнэт цаас гаргагч болон 50 000 000 000 (тавин тэрбум) төгрөгөөс дээш зах зээлийн үнэлгээтэй үнэт цаас гаргагчийн олон нийтэд эзэмшүүлэх хувь хэмжээнд хөнгөлөлт үзүүлж болно;
- 11.3.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 300-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдана. Анх хувьцаа бүртгүүлэх үед энэхүү шалгуурыг харгалзахгүй байж болно.
- 11.3.4. Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

Арван хоёрдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуур

- 12.1. Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуур хангасан байна. Үүнд:

- 12.1.1 Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
 - 12.1.2 Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Сүүлийн жилийн аудитын тайлангийн дүгнэлт нь “Зөрчилгүй санал дүгнэлт” эсхүл “Хязгаарлалттай санал дүгнэлт” байна. Хорооноос зөвшөөрсөн арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтад багтсан биржид бүртгэлтэй гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд, гадаад улсын биржид мөрддөг санхүүгийн тайлагналын аливаа стандартын дагуу тайлagnaхыг зөвшөөрөх ба Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS) болон тайланд ашигласан стандартын дагуу санхүүгийн үзүүлэлтэд орох материаллаг зөрүүгийн тухай тайлбар гаргана;
 - 12.1.3 Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд 800 000 000 (найман зуун сая) төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой байх ба орлого, зардал, цэвэр ашгийн тооцоололд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлого, зардал, онцгой шинжтэй олз, гарзыг тооцохгүй;
 - 12.1.4 Компани бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капитал (эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн)-тай байх эсхүл 200 000 000 (хоёр зуун сая) төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх;
 - 12.1.5 Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;
- 12.2. Уул уурхайн компани нь журмын 12.1-т заасан шалгуураас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 12.2.1. Хөндлөнгийн мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн тооцоолсон 5 жилээс доошгүй хугацаанд олборлох баттай эсхүл магадлалтай ашигт малтмалын ордын нөөцтэй байх;
 - 12.2.2. Хөрөнгийн бүтцийн 30-аас доошгүй хувь нь өөрийн хөрөнгө байх;
 - 12.2.3. 1 500 000 000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр биет хөрөнгө (нийт хөрөнгөөс нийт өр төлбөр, давуу эрхийн хувьцаа, биет бус хөрөнгийг хассан дүн)-тэй байх.
- 12.3. Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх/бүртгүүлсэн үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна:
 - 12.3.1. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 3 000 000 000 (гурван тэрбум) төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно;
 - 12.3.2. Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 20-оос доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах, эсхүл үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ 20 000 000 000 (хорин тэрбум)

- төгрөгөөс дээш бол олон нийтэд эзэмшигчийн тоо 200-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдана. Анх хувьцаа бүртгүүлэх үед энэхүү шалгуурыг харгалзахгүй байж болно;
- 12.3.4. Энэ журмын 11.3.4-т заасан шалгуурыг хангах.

Арван гуравдугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн III ангиллын шалгуур

- 13.1 Хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах нөхцөл, шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 13.1.1 Хувьцааны бүртгэлийн III ангилалд үйл ажиллагаа явуулсан байвал зохих хугацааны шалгуур болон үнэт цаасны олон нийтийн эзэмшилд байх доод хэмжээг тогтоогоогүй, хувьцаагаа энэ журмын 13.1.2-т заасан этгээдэд санал болгон арилжаалдаг, шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, бизнесийн мөчлөгийн өсөлтийн үе шатанд буй жижиг, дунд хэлбэрийн компани эсхүл хайгуулын, ашиглалтын лиценз бүхий уул уурхайн компаниуд хувьцаагаа бүртгүүлэн, арилжиж болно;
- 13.1.2 Хувьцааны бүртгэлийн III ангиллын үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаална;
- 13.1.3 Хувьцааны бүртгэлийн III ангиллын үнэт цаасыг энэ журмын 13.1.2-т заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерын үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бичгээр мэдэгдсэн байна.
- 13.1.4 Сүүлийн жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Хорооноос зөвшөөрсөн хөрөнгийн биржийн жагсаалтад багтсан биржид бүртгэлтэй гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд, гадаад улсын биржид мөрддөг санхүүгийн тайлагналын аливаа стандартын дагуу тайлагнахыг зөвшөөрөх ба Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон тайланд ашигласан стандартын дагуу санхүүгийн үзүүлэлтэд орох материаллаг зөрүүгийн тухай тайлбар гаргана;
- 13.1.5 Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд борлуулалтын орлого олж, цэвэр ашигтай ажилласан байна. Орлого, зардал, цэвэр ашгийн тооцоололд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлого, зардал, онцгой шинжтэй олз, гарзыг тооцохгүй.
- 13.2. Хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

13.2.1. Энэхүү журмын 13.1.1-т заасан шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, бизнесийн мөчлөгийн өсөлтийн үе шатанд буй жижиг, дунд хэлбэрийн компани дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

13.2.1.1. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;

13.2.1.2. Зах зээлийн үнэлгээ нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан Биржээс тухай бүр тогтоосон шаардлагыг хангасан байх;

13.2.1.3. Энэ журмын 11.3.4-т заасан шалгуурыг хангах;

13.2.2. Энэхүү журмын 13.1.1-т заасан хайгуулын лиценз бүхий уул уурхайн компаниуд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

13.2.2.1. Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доoshгүй жил нэг чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх эсхүл үнэт цаас гаргагчийн удирдлага нь хайгуулын үйл ажиллагаа явуулах талаар хангалттай мэдлэг, туршлагатай болохыг баталгаажуулах;

13.2.2.2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй байх;

13.2.2.3. Ашигт малтмалын таамагласан эсхүл боломжтой нөөц бүхий орд газрын 50-аас доoshгүй хувийг эзэмшдэг байх;

13.2.2.4. хөндлөнгийн мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн гаргасан техникийн тайлангийн дагуу 500 000 000 (таван зуун сая) төгрөгөөс доoshгүй өртөг бүхий ажлын төлөвлөгөө гаргасан байх;

13.2.2.5. Биржид бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа, үүнд ерөнхий ба удирдлагын зардал, хөрөнгийн зардал, төлөвлөгдсөн хайгуулын болон хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлэх болон ажлын төлөвлөгөөг биелүүлэхэд хүрэлцэхүйц ажлын капитал (эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн)-тай байх;

13.2.2.6. 500 000 000 (таван зуун сая) төгрөгөөс доoshгүй хэмжээний цэвэр биет хөрөнгө (нийт хөрөнгөөс нийт өр төлбөр, давуу эрхийн хувьцаа, биет бус хөрөнгийг хассан дүн)-тэй байх;

13.2.2.7. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчид дараах шалгуур, шаардлага тавигдана. Үүнд:

13.2.2.7.1. Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институтийн мэргэжлийн бүртгэлийн гэрчилгээ бүхий гишүүн эсхүл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлтэй мэргэжилтэн байх;

13.2.2.7.2. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь эрдэсжилтийн хэлбэр, ордын төрлийн талаар 5-аас доoshгүй жилийн мэдлэг туршлагатай, идэвхтэй ажилласан

байх. Хэрэв хайгуулын ажлын үр дүнгийн тайлан бичиж байгаа бол хайгуулын талаар холбогдох дадлага туршлагатай, ашигт малтмалын нөөцийн үнэлгээг тооцоолох буюу хяналтыг хийж байгаа бол ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээ, бодолт, эдийн засгийн олборлолтын талаар холбогдох дадлага туршлагатай байх;

13.2.2.7.3. Үнэт цаас гаргагч, түүний ТУЗ, гүйцэтгэх удирдлага, болон зөвлөхүүдээс хараат бус байх;

13.2.2.7.4. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь журмын 13.2.2.8-д заасан тайлагналын стандартын дагуу техникийн тайлан бэлтгэдэг байх ба тайлангийн хүчинтэй байх хугацаа нь Биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 6 сарын дотор байх;

13.2.2.7.5. Техникийн тайланда геологи-хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн тооцооны талаар хангалттай сайн үзүүлсэн байх;

13.2.2.7.6. Техникийн тайлангийн талаар бүх хариуцлагыг хүлээх.

13.2.2.8. Ашигт малтмалын баялаг, ордын нөөц болон геологи-хайгуулын ажлын үр дүнгийн тухай мэдээллийг “Монголын нөөц тайлагнах журам” МНТ (MRC code) эсхүл Канад улсын “Үндэсний баримт бичиг” (NI 43-101), Австрали улсын “Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг болон хүдрийн нөөц тайлагнах журам” (JORC code), Өмнөд Африкийн “Ашигт малтмалын баялаг болон нөөц тайлагнах журам” (SAMREC code) гэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын стандартуудын аль нэгээр, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайланг “Монголын нөөц тайлагнах журам” МНТ (MRC code) эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Канадын улсын “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний журам” (CIMVAL code), “Үндэсний баримт бичиг” (NI 43-101), Өмнөд Африкийн “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлагналын журам” (SAMVAL code), Австрали улсын “Ашигт малтмалын хөрөнгийн болон техникийн үнэлгээг олон нийтэд тайлагнах журам” (VALMIN code) гэсэн стандартуудын аль нэгээр тус тус тайлагнах;

13.2.2.9. Өргөдөл гаргахаас өмнөх сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна;

13.2.2.10. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;

- 13.2.2.11. Хувьцааны зах зээлийн үнэлгээ нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан Биржээс тухай бүр тогтоосон шаардлагыг хангасан байх;
- 13.2.2.12. Энэ журмын 11.3.4-т заасан шалгуурыг хангах.
- 13.2.3. Энэхүү журмын 13.1.1-т заасан ашиглалтын лиценз бүхий уул уурхайн компаниуд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 13.2.3.1 Хөндлөнгийн мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн тооцоолсон 10-аас доoshгүй жилийн баттай эсхүл магадлалтай ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах эрхтэй байх;
- 13.2.3.2. Уул уурхайн үйлдвэрлэлийг арилжааны түвшинд авчрах ажлын төлөвлөгөөтэй байх;
- 13.2.3.3. Төсөвлөгдсөн хөрөнгө оруулалтыг хийх болон уул уурхайн үйлдвэрлэл явуулахад хүрэлцэхүйц нөөц хөрөнгөтэй байх;
- 13.2.3.4. 1 000 000 000 (нэг тэрбум) төгрөгөөс доoshгүй цэвэр биет хөрөнгө (нийт хөрөнгөөс нийт өр төлбөр, давуу эрхийн хувьцаа, биет бус хөрөнгийг хассан дүн)-тэй байх ба ирээдүйн ашигт ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлээр нотолсон байх;
- 13.1.7.5 Энэхүү журмын 13.2.2.7-13.2.2.12-т заасан шалгуурыг хангах.

- 13.3. Хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэх/бүртгүүлсэн үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна. Үүнд:
- 13.3.1. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 1 000 000 000 (нэг тэрбум) төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно;
- 13.3.2. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доoshгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдана. Ах хувьцаа бүртгүүлэх үед энэхүү шалгуурыг харгалзахгүй байж болно;

Арван дөрөвдүгээр зүйл. Өрийн хэрэгслийн шалгуур

- 14.1. Биржид өрийн хэрэгсэл бүртгүүлэхээр өргөдөл гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 14.1.1. Биржийн хувьцааны бүртгэлийн I эсхүл II ангиллын шалгуурыг бүрэн хангасан байх;
- 14.1.2. Зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;
- 14.1.3. Өмнө нь нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргасан бол хоёр болон түүнээс дээш удаа өрийн хэрэгслийн хүүгийн болон үндсэн төлбөрийг тогтсон хугацаанаас хоцроож, төлбөрийн тасалдал учруулж байгаагүй байх.
- 14.2. Өрийн хэрэгсэл гаргагч нь өргөдөл гаргах үед энэ журмын 14.1-т заасан шалгуураас гадна дараах шалгуурын аль нэгийг хангасан байна. Үүнд:
- 14.2.1 Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дундаж ашгийн хэмжээ нь өрийн хэрэгслийн 1 жилийн хүүгийн төлбөрийн хэмжээтэй дүйцэх дүнтэй байх

- ба өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж чадах хангалттай хэмжээний буюу үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаатай байх;
- 14.2.2 Засгийн газраас, Монгол Улсын хөгжлийн банкнаас эсхүл Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагаас бүхэлд нь баталгаа гаргасан байх;
- 14.2.3 Дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын “тогтвортой” эсхүл түүнээс дээш түвшний зэрэглэл тогтоолгосон байх. Дотоодын зэрэглэл тогтоох этгээд нь зэрэглэл тогтоох чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх ба тус компанийн тогтоосон зэрэглэлийн үр дүнгээс үүдэн хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч ба эзэмшигчид хохироогүй байх, тийн үйлдэл гаргаагүй байх.
- 14.3. Өрийн хэрэгсэл нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 14.3.1. Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх;
- 14.3.2. Хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн хувьд хөрвөх хувьцааны тоо нь компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувиас хэтрэхгүй байх, Биржээс тогтоосон олон нийтийн эзэмшлийн хувь хэмжээний шаардлагыг хангаж байх.
- 14.4. Биржид бүртгүүлэх өрийн хэрэгслийг гаргах этгээд нь андеррайтертай гэрээ байгуулах бөгөөд тухайн өрийн хэрэгслийг санал болгож буй цар хүрээ, гаргаж буй этгээдийн онцлог зэргээс хамаарч бусад андеррайтерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй хамтран ажиллаж болно.
- 14.5. Хөрвөх өрийн хэрэгслийн хувьд хөрвөх хувьцаа нь Биржид бүртгэлтэй байна.
- 14.6. Ногоон бонд болон бонд гаргах хөтөлбөрийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
- 14.7. Өрийн хэрэгсэл худалдан авагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, тэдэнд эрсдэл учрах магадлалтай гэж үзвэл эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг барьцаагаар баталгаажуулахыг эсхүл хөндлөнгийн этгээдээр баталгаа гаргуулахыг тус тус шаардаж болно.
- 14.8. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, баталгаа, батлан даалт нь Иргэний хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангасан байна.

Арван тавдугаар зүйл. Бүртгэлийн шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх

- 15.1. Үнэт цаас гаргагч, түүнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээд нь энэхүү журмаар тогтоосон хувьцааны ангиллын шалгуур болон өрийн хэрэгслийн шалгуураас чөлөөлүүлэх буюу хөнгөлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтээ Биржид гаргах эрхтэй.
- 15.2. Биржийн I, II ангиллын шалгууруудыг дараах тохиолдолд хөнгөлөх буюу чөлөөлж болно. Үүнд:

15.2.1. Улсын болон бус нутгийн эдийн засгийн хөгжилд өндөр ач холбогдол бүхий “дэд бүтцийн төсөл”-ийг хэрэгжүүлэх компани хамаарах ба дараах шаардлагуудыг хангана. Үүнд:

- 15.2.1.1 Дэд бүтцийн төслийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байх;
 - 15.2.1.2 Биржид бүртгүүлэх хүсэлт гаргах үедээ дэд бүтцийн төсөл болон гэрээнд тусгаснаас өөр бизнесийн үйл ажиллагаа явуулаагүй байх;
 - 15.2.1.3 Дэд бүтцийн төсөл нь урт хугацааны концессын гэрээ эсхүл тусгай эрхийн дагуу явагдах;
 - 15.2.1.4 Хэрэв нэг болон түүнээс олон төслийг хэрэгжүүлж байгаа бол эдгээр төслүүдийн дийлэнх нь бүтээн байгуулалтын болон түүний өмнөх үе шатанд байх;
 - 15.2.1.5 Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг өр төлбөр төлөх болон төслийн бус хөрөнгө худалдах авах зорилгоор зарцуулахгүй байх;
 - 15.2.1.6 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон удирдлага нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн мэдлэг, өмнө нь төсөл амжилттай хэрэгжүүлж байсан туршлагатай байх;
 - 15.2.1.7 Хөрөнгийн үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэл, мөнгөн хөрөнгийн төлөвлөлт зэрэг баримт бичгийг толилуулах.
- 15.2.2. Бирж тухайн үнэт цаас гаргагчийг хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, эрэлт ихээр үүсгэсэн гэж үзсэн онцгой тохиолдол;
- 15.2.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч хоёрдогч бүртгэл хийлгэхээр хүсэлт гаргасан тохиолдол;
- 15.2.4. Нэгдсэн үндэстний байгууллагаас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн зорилгуудад (цаашид “ТЗХ” гэх)-д чиглэсэн үйл ажиллагааны дотоодын эсхүл олон улсын ангилал, тодорхойлолт буюу “ТЗХ таксономи”-д нийцсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх тохиолдол;
- 15.2.5. Монгол Улсын “Ногоон таксономи”, эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” үйл ажиллагааг санхүүжүүлэх тохиолдол.
- 15.3. Хувьцаа нь Биржид бүртгэлтэй этгээд нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд тодорхой шалгуураас хөнгөлүүлэх хүсэлтийг Биржид гаргаж болно.
- 15.4. Энэхүү журмын 2.11-д заасан этгээдийн үнэт цаасыг бүртгэхдээ дараах төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу үзүүлж болно. Үүнд:
- 15.4.1. Тус эдгээд нь өрийн хэрэгсэл гарган, бүртгүүлэх тохиолдолд энэ журмын 11.1.2, 12.1.2-д заасан шалгуурын хугацааг 1 жил болгон хөнгөвчлөх;
 - 15.4.2. Биржид үнэт цаас бүртгүүлэхэд журмын 11.1.1, 12.1.1-д заасан үйл ажиллагаа явуулсан жилийн шалгуураас чөлөөлөх;
 - 15.4.3. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр тухайн жил шалгарсан этгээд 1 жил хүртэл хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд үргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус

хөрөнгийг барьцаалахгүй эсхүл санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгохгүй байж болно.

- 15.5. Энэхүү журмын 15.2-15.4-т заасан асуудлыг Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА

Арван зургадугаар зүйл. Давуу эрхийн хувьцаа бүртгүүлэх хүсэлт гаргах, хянан шийдвэрлэх

- 16.1. Үнэт цаас гаргагч нь давуу эрхийн хувьцааг Биржийн бүртгэлд бүртгүүлэхийн өмнө энэ журмын 2 дугаар зүйлд заасан бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийг хангаж, журмын 3 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх хүсэлтийг гаргана.
- 16.2. Үнэт цаас гаргагч нь давуу эрхийн хувьцаа бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнө давуу эрхийн хувьцааны нөхцөл нь тухайн ангиллын үнэт цаасны нөхцөл, шаардлагын талаар Биржээс зөвлөгөө авч болно.
- 16.3. Энэ журмын 4 дүгээр зүйлд заасан Үнэт цаасны танилцуулгад давуу эрхийн хувьцаатай холбоотой дор дурдсан мэдээллийг нэмж тусгана. Үүнд:
- 16.3.1. Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээ;
 - 16.3.2. Ногдол ашиг нь хуримтлагдах/хуримтлагдахгүй эсэх тухай;
 - 16.3.3. Давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл, түүнийг хэрэгжүүлэх журам;
 - 16.3.4. Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасан бусад нөхцөлүүд.
- 16.4. Давуу эрхийн хувьцааг бүртгүүлэх өргөдлийг хянан шалгах ажиллагааг зохион байгуулах болон бүртгэх, бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргах ажиллагаа нь энэ журмын 8 дугаар зүйлд заасантай нэгэн адил байна.

Арван долдугаар зүйл. Давуу эрхийн хувьцаанд тавигдах шалгуур, шаардлага

- 17.1. Давуу эрхийн хувьцаагаа биржид бүртгүүлэх өргөдөл гаргагч нь дараах этгээд байна. Үүнд:
- 17.1.1. Энгийн хувьцаа нь Биржийн хувьцааны I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч;
 - 17.1.2. Энгийн хувьцаагаа Биржийн хувьцааны I ангилалд бүртгүүлэхээр хүсэлт гаргагч.
- 17.2. Давуу эрхийн хувьцаа гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 17.2.1. Энгийн хувьцаа нь Биржийн I ангиллын шалгуур шаардлагыг хангаж байх. Биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьд үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, бүртгэлээс хасагдах нөхцөл үүсээгүй байх;
 - 17.2.2. Бүртгүүлэх давуу эрхийн хувьцааны зах зээлийн үнэлгээ нь 1 тэрбум төгрөгөөс доошгүй байх;
 - 17.2.3. Нийт гаргасан давуу эрхийн хувьцааны 10-аас доошгүй хувийг нийтэд санал болгосон байх;
 - 17.2.4. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-иас доошгүй байх;
 - 17.2.5. Давуу эрхийн хувьцааны үлдсэн хугацаа болон энгийн хувьцаанд хөрвөх хугацаа нь 1 жилээс доошгүй байх;
 - 17.2.6. Бүртгүүлэх үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх;

- 17.2.7. Давуу эрхийн хувьцааны нөхцөлд заасан ногдол ашгийг төлөх хангалттай хэмжээний ашигтай ажилладаг байх;
- 17.2.8. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад.
- 17.3. Давуу эрхийн хувьцаа гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаандаа журмын зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллах үүрэгтэй ба мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмуудыг хэрэгжүүлэн ажиллана.
- 17.4. Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энгийн хувьцаатай холбоотой “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын бусад зохицуулалтууд давуу эрхийн хувьцаа гаргагчид нэгэн адил үйлчилнэ.

Арван наймдугаар зүйл. Давуу эрхийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах

- 18.1. Давуу эрхийн хувьцааг нэмж гаргах, давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэгт өөрчлөлт оруулах зэрэг давуу эрхийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулахад энэ журмын Долдугаар бүлэгт заасныг баримтална.

Арван есдүгээр зүйл. Давуу эрхийн хувьцааг бүртгэлээс хасах

- 19.1 Бирж нь дараах тохиолдолд давуу эрхийн хувьцааг Биржийн бүртгэлээс хасна.
Үүнд:
 - 19.1.1 Биржид бүртгэлтэй энгийн хувьцаа нь бүртгэлээс хасагдсан;
 - 19.1.2 Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, Биржээс тогтоосон шалгуур шаардлагыг удаа дараа биелүүлээгүй;
 - 19.1.3 Үнэт цаас гаргагч өөрөө хүсэлт гаргасан;
 - 19.1.4 Хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлнө гэж Бирж үзсэн бусад тохиолдол.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Хорьдугаар зүйл. Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах

- 20.1. Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь өрийг хувьцаагаар солих, ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, энгийн хувьцаанд суурилсан хувьцаа худалдан авах эрхийн опцион гаргах, ногдол ашгийг үнэт цаасаар олгох, стратегийн хөрөнгө оруулагчид эзэмшүүлэх зорилгоор хаалттай хүрээнд нэмж хувьцаа, хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг гаргах зэргээр урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд нэмж гаргах тохиолдолд Хороо ба Биржийн бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд Хорооны журамд Биржид зөвхөн мэдэгдэх талаар тухайллан зааснаас бусад тохиолдолд уг өөрчлөлтийг Биржид бүртгүүлнэ.
- 20.2. Ногдол ашгийг үнэт цаасаар олгохоор шийдвэрлэсэн бол уг шийдвэрт дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 20.2.1 Нэгж хувьцаанд ногдох нэмэлт үнэт цаасны тоо ширхэг;
 - 20.2.2 Ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмших эрхтэй хувьцаа эмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр.

- 20.3. Ногдол ашиг хэлбэрээр нэмж гаргах үнэт цаасны нийт үнэ нь уг компанийн хурийтлагдсан ашгийн дүнгээс ихгүй байна.
- 20.4. Ногдол ашиг хэлбэрээр олгохоор нэмж гаргах үнэт цаасыг Биржид хялбаршуулсан журмаар бүртгэх бөгөөд бүртгэсэн тухай мэдээллийг Хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэнээс хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.
- 20.5. Энэ журмын 20.1-д заасны дагуу зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргаж байгаагаас бусад тохиолдолд үнэт цаас гаргах тухай асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргасан байна.
- 20.6. Тухайн компани энэхүү журмын 20.5-т заасан шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор ийнхүү шийдвэрлэсэн хурлын материалыг Биржид хүргүүлэх бөгөөд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт 30 хоногийн дотор Биржид хүргүүлнэ.
- 20.7. Үнэт цаас нэмж бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:
 - 20.7.1. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл (Маягт 1);
 - 20.7.2. Үнэт цаас гаргах тухай асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, материал, түүнд холбогдох баримт бичиг;
 - 20.7.3. Үнэт цаас нэмж гаргах төсөл;
 - 20.7.4. Үнэт цаас нэмж гаргах замаар санхүүжилт татаж байгаа бол түүнийг зарцуулахтай холбоотой бизнес төлөвлөгөө;
 - 20.7.5. Компанийн тухай хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу тогтоосон нэгж хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах, эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх, нэгж үнэт цаасыг нийтэд санал болгох үнийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 20.7.6. Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, түүнийг баталсан эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 20.7.7. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам;
 - 20.7.8. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт 3);
 - 20.7.9. Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт;
 - 20.7.10. Андеррайтерийн компанийн байгуулсан гэрээ болон тодорхойлох захидал;
 - 20.7.11. Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад.
- 20.8. Үнэт цаас гаргагч нь нэмж гаргасан хувьцааг ажиллагсдад эзэмшүүлэхээр, өрийг солихоор болон стратегийн хөрөнгө оруулагчид эзэмшүүлэхээр хаалттай хүрээнд санал болгож байгаа бол Биржээс тогтоосон олон нийтийн эзэмшлийн хувь хэмжээний шаардлагыг хангахгүй болох үр дагаварт хүргэхээргүй нөхцөлд үнэт цаасны танилцуулга бэлдэхгүй, хуулийн болон үнэлгээний дүгнэлт гаргуулахгүйгээр нэмж гаргаж буй үнэт цаасаа Биржид бүртгүүлж болно.
- 20.9. Энэ журмын 20.8-д заасны дагуу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдээлэлд дараах баримт бичгийг хавсарган Биржид хүргүүлнэ. Үүнд:
 - 20.9.1. Өрийг хувьцаагаар сольж байгаа бол өр үүссэн нөхцөл байдал, холбогдох гэрээ, шийдвэр, санхүүгийн тайланд тусгасныг нотолсон аудиторын дүгнэлт, өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсөн авлагатай

- этгээдийн шийдвэр, өрийг солих нэгж хувьцааны үнийг тооцсон үндэслэл, зарцуулалт;
- 20.9.2. Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр нэмж хувьцаа гаргаж байгаа бол уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, хөтөлбөрийг танилцуулсан тухай мэдээлэл, хөтөлбөрт хамрагдахыг зөвшөөрч байгаа ажиллагсдын жагсаалт, ажилтанд хувьцаа эзэмшүүлэх нөхцөл, саналын эрхийг хэрэгжүүлэх журам.
- 20.10. Компани нь өөрийн хувьцааг тохиролцсон үнээр, тогтсон хугацаанд худалдах тухай энгийн хувьцаанд суурилсан опцион гэрээг компанийн ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эсхүл компанийн гүйцэтгэх удирдлага, түүний удирдлагын багийг урамшуулах зорилгоор гаргаж байгаа бол опцион бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:
- 20.10.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;
- 20.10.2. Опцион гаргахтай холбоотой зохицуулалт тусгагдсан компанийн дүрмийн төсөл;
- 20.10.3. Опционы үнэ, хугацаа, хэрэгжүүлэх хуваарь, худалдан авч болох хувьцааны тоо зэрэг мэдээллийг агуулсан опционы талаарх дэлгэрэнгүй танилцуулга;
- 20.10.4. Опцион хуваарилах ажиллагааны журам;
- 20.10.5. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;
- 20.10.6. Компанийн нэмж гаргах опционы хэмжээ нь тухайн компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 15 хувиас хэтрэхгүй;
- 20.10.7. Компанийн опционд заасан энгийн хувьцааны үнэ нь Компанийн тухай хуулийн 40.3-т заасан арилжааны жигнэсэн дундаж үнээс доошгүй байна;
- 20.10.8. Компанийн опционы хугацаа дуусгавар болох эсхүл опционы эрхийг хэрэгжүүлэх хүртэл тухайн компанийн нэмж бүртгэгдэх хувьцаа нь зарласан хувьцаа байна.
- 20.11. Өрийн хэрэгсэл гаргагч нь хүүгийн болон үндсэн төлбөрийг төлөх боломжгүй болсон тохиолдолд бондын гэрээнд нэг удаа өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд өрийн эргэн төлөлтийн төлөвлөгөө боловсруулж, эрх бүхий этгээдийн шийдвэр гаргуулан Биржид хүргүүлж олон нийтэд мэдээлнэ.
- 20.12. Үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгон гаргах үед төлбөрийг эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийхийг үнэт цаас гаргагч нь зөвшөөрсөн бол төлбөрт хүлээн авч буй хөрөнгийн жагсаалт, эдгээр хөрөнгө нь компанийд ямар шалтгаанаар зайлшгүй хэрэгтэй болох тухай тайлбар, танилцуулга, үнэлгээний байгууллагын дүгнэлт, түүнийг үндэслэн гаргасан ТУЗ-ийн шийдвэрийн хувийг Биржид хүргүүлнэ.
- 20.13. Үнэт цаас гаргагч нь хаалттай хүрээнд санал болгон хувьцаа нэмж гаргаж байгаа үед уг хувьцааг худалдах үнийг тухайн хувьцааны арилжааны сүүлийн 6 сарын болон сүүлийн 30 хоногийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10

хувиас бага үнээр тогтоохоор шийдвэрлэсэн бол тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдээ заавал олгоно.

- 20.14. Бирж нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай асуудлаар хийгдсэн шалгалтын тайланд үндэслэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг Бүртгэлийн Хороо (байхгүй бол Захирлын зөвлөлийн хурал)-гоор хэлэлцүүлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 20.15. Бирж нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай шийдвэрийн хувийг Хороонд, Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл (Маягт 5) болон шийдвэрийн хуулбарыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжааны төлбөр, тооцооны байгууллагуудад тус тус хүргүүлнэ.

Хорин нэгдүгээр зүйл. Нийтэд санал болгон нэмж үнэт цаас гаргах

- 21.1. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж үнэт цаас гаргахад энэ журмын хоёрдугаар бүлэгт заасан журмыг баримтална.
- 21.2. Үнэт цаас нэмж гаргах хүсэлтэд энэхүү журмын 2 дугаар бүлэгт болон 20.7-д заасан холбогдох баримт бичгүүд болон энэ журмын хавсралт 4-т тусгасан үнэт цаас гаргагчийн мэдэгдлийг хавсаргасан байна.

Хорин хоёрдугаар зүйл. Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

- 22.1. Үнэт цаас гаргагч нь нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Биржид хүргүүлнэ. Үүнд:
 - 22.1.1. Компанийг өөрчлөн байгуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;
 - 22.1.2. Компанийн тухай хуульд заасан асуудлыг бүрэн тусгасан компанийг өөрчлөн байгуулах төсөл;
 - 22.1.3. Үнэт цаас гаргагчийн нэгтгэн авч буй компанийн эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 22.1.4. Нэгтгэгдэж буй компанийн хувьцааг үнэт цаас гаргагчийн хувьцаанд хөрвүүлэх харьцаа, урьдчилсан байдлаар гаргасан санхүүгийн тайлан, түүний үндэслэл;
 - 22.1.5. Компанийг хувааж байгаа тохиолдолд хуваах баланс, хуваалтаар үүссэн компани бүрийн хувьцааны тоог тодорхойлсон журам;
 - 22.1.6. Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахтай холбоотой үүссэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам;
 - 22.1.7. Өөрчлөн байгуулалтаар бий болж байгаа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, өр төлбөр, эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, эрх, үүрэг шилжүүлэх тухай мэдэгдэл;
 - 22.1.8. Нэгдэж буй болон нэгтгэж буй компани тус бүрийн сүүлийн 6 сарын доторх хугацааны аудитын компаниар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
 - 22.1.9. Нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгтгэхэд ашигласан арга, аргачлал;
 - 22.1.10. Нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулан хийсэн хууль зүйн дүгнэлт;
 - 22.1.11. Хуулийн дагуу өөрчлөлт оруулах шаардлагагүйгээс бусад тохиолдолд нэгтгэсний дараах байдлаар хийгдсэн компанийн дүрмийн төсөл;

- 22.1.12. Ногдол ашиг хуваарилсан байдал, ногдол ашгийн үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны хадгаламж дахь дансанд байршуулсан тухай баримт;
- 22.1.13. Журмын 22.2-т заасныг нотлох баримт;
- 22.1.14. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Хавсралт 4);
- 22.1.15. Журмын 26.2.1; 26.2.2-т заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 22.2. Өөрчлөн байгуулах төслийг Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмаар хувьцаа эзэмшигчдэд хүргэж саналыг авах ажлыг зохион байгуулсан байна.
- 22.3. Биржийн хувьцааны бүртгэлийн II, III ангилаалд багтдаг, нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшилд нийт хувьцааны 90-ээс дээш хувь нь төвлөрсөн, үйл ажиллагаа нь зогсонги байдалтай үнэт цаас гаргагчтай дараах хуулийн этгээд нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Үүнд:
- 22.3.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч;
- 22.3.2. Тухайн жилийн компанийн нийт хөрөнгө нь 5.0 тэрбум төгрөгөөс дээшгүй, борлуулалтын орлого нь 1.0 тэрбум төгрөгөөс дээшгүй аж ахуйн нэгж.
- 22.4. Үнэт цаас гаргагч нь компанийн оноосон нэр, үсгэн код өөрчлөх, нэрлэсэн үнэ өөрчлөх, үнэт цаасны төрөл хэлбэрийг өөрчлөх, опцион, өрийн хэрэгслийг хувьцаанд хөрвүүлэх, бүртгэлтэй үнэт цаасыг хэсэгчлэн хасах зэрэг тохиолдолд хууль, дүрэм журмын дагуу баримт материалыг бүрдүүлэн ирүүлэх ба Биржийн гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.

Хорин гуравдугаар зүйл. Үнэт цаасыг хуваах, нэгтгэх

- 23.1. Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан үнэт цаасыг хуваах, нэгтгэхээр шийдвэрлэсэн бол үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг Биржид хүргүүлэх ба уг төсөлд дараах зүйлийг тусгана. Үүнд:
- 23.1.1 Үнэт цаасыг хувааж, нэгтгэх тухай ХЭХ-ын шийдвэр;
- 23.1.2. Үнэт цаасыг хуваах, нэгтгэх үндэслэл, уг ажиллагааг гүйцэтгэх журам;
- 23.1.3. Үнэт цаасыг хуваах, нэгтгэх харьцаа, тооцоолол;
- 23.1.4. Үнэт цаасыг хуваах, нэгтгэхтэй холбоотой үүссэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам;
- 23.1.5. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт 3);
- 23.1.6. Журмын 26.2.1-т заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 23.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг нэгтгэхэд үлдэх бутархай үлдэгдлийг Компанийн тухай хуульд заасан зах зээлийн үнээр худалдан авна.
- 23.3. Үнэт цаасыг хуваасан, нэгтгэсний үр дүнд үнэт цаасны бүртгэлд гарсан өөрчлөлтийг Бирж бүртгэж, өөрчлөлтийг бүртгэсэн тухай Хороо болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжааны төлбөр, тооцооны байгууллагуудад ажлын 3 өдрийн дотор мэдэгдэнэ.

Хорин дөрөвдүгээр зүйл. Бүртгэлийн ангилал тогтоох

- 24.1 Бирж нь бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны бүртгэлийн ангиллыг тухайн тайлангийн жилийн эхний 6 сард багтаан жилд нэгээс доошгүй удаа шинэчилнэ.
- 24.2 Тухайн жилд журмын 24.1-д заасан хугацаанаас өмнө эсхүл хойш ангиллыг ахиулах болон бууруулах асуудлыг журмын 24.3, 24.4 дэх заалтад заасны дагуу шийдвэрлэнэ. Бүртгэлийн ангилал ахиулах асуудлыг үнэт цаас

гаргагчийн хүсэлтийг үндэслэн эсхүл Биржийн санаачилгаар тус тус Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

24.3 Бүртгэлийн ангилал ахиулж бүртгэх:

- 24.3.1. II ангилалд бүртгэлтэй байгаа үнэт цаас гаргагч I ангиллын, III ангилалд бүртгэлтэй байгаа үнэт цаас гаргагч II ба I ангиллын шалгуурыг тус тус бүрэн хангасан гэсэн үндэслэлээр ангилал ахиулж бүртгүүлэхээр Биржид хүсэлтээ гаргаж болно;
- 24.3.2. Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан нь ангилал ахиулах хүсэлт гаргахаас өмнөх 6 сарын хугацаанд хууль, дүрэм, журам, гэрээ зөрчиж, хариуцлага хүлээгээгүй байна;
- 24.3.3. Ангилал ахиулан бүртгүүлэх хүсэлтийг тухайн ангиллын шалгуурыг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хамт бүрдүүлэн хүргүүлнэ;
- 24.3.4. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн ангилал ахиулж бүртгэх тухай Биржийн шийдвэр гарснаас хойш ажлын нэг өдөрт багтаан олон нийтэд мэдэгдэнэ;
- 24.3.5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь бүртгэлийн ангилал ахиулж бүртгүүлсэн тохиолдолд өмнөх ангилалд бүртгэлтэй байсан хөрвөх хувьцаа хэлбэрийн үнэт цаас, түүнтэй төстэй эрхүүд, опцион зэрэг нь нэгэн зэрэг ангилал ахиж бүртгэгдэнэ;
- 24.3.6. Бирж бүртгэлийн шалгуур хангаж байгаа үнэт цаасыг үнэт цаас гаргагчид мэдэгдсэний үндсэн дээр ангилал ахиулж бүртгэж болно.

24.4 Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэх:

- 24.4.1 I ангиллын шалгуурыг бүрэн хангахгүй болсон хэдий ч II ангиллын шалгуурыг хангаж байгаа, II ангиллын шалгуураа бүрэн хангахгүй болсон хэдий ч III ангиллын шалгуурыг хангаж байгаа үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Биржийн санаачилгаар эсхүл үнэт цаас гаргагчийн хүсэлтээр ангилал бууруулж бүртгэж болно.
- 24.4.2 Бирж нь журмын 24.4.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө үнэт цаас гаргагчид мэдэгдэх бөгөөд ангиллын шаардлагатай холбоотой хугацаа тавьж үүрэг өгч болно.
- 24.4.3 Бүртгэлийн ангилал бууруулж бүртгэхэд энэ журмын 20.3.4-д заасан олон нийтэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалт нэгэн адил хамаарна.

24.5 Энэхүү журмын 24-т заасан асуудлыг Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

Хорин тавдугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг

- 25.1. Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.
- 25.2. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа энэхүү журамд заасан өрийн хэрэгслийн болон хувьцааны харгалзах ангиллын зохих шалгуурыг хангаж ажиллана.

- 25.3. Санхүүгийн тайлан тэнцлийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж, зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар тогтмол баталгаажуулна.
- 25.4. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон ногдол ашиг хуваарилах зэргийг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэрийг баримтлах бөгөөд уг ажиллагааг өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулна.
- 25.5. Үнэт цаастай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хувьцаа эзэмшигч, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий үнэт цаас хариуцсан ажилтантай байна.
- 25.6. Үнэт цаас гаргагч нь Хорооны "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмуудыг үйл ажиллагаанд даац дагаж мөрдөнө. Хувьцааны I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1-ээр батлагдсан Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягтын дагуу кодексийн зүйл тус бүрээр хэрэгжилт эсхүл тайлбарыг бүрэн гаргаж, ханган ажилласан байна.
- 25.7. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа холбогдох журам болон гэрээнд заасны дагуу жилийн үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 25.8. Үнэт цаас гаргагч нь Биржтэй байгуулсан Бүртгэлийн гэрээнд заасан үүргээ бүртгэлтэй байх хугацаандаа бүрэн биелүүлж ажиллана.
- 25.9. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаар, мөн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээлэл болон хууль болон Хороо, Биржийн холбогдох журам, заавар, гэрээний дагуу мэдээлэх шаардлагатай мэдээллийг заасан хугацаанд Хороо, Бирж, олон нийтэд мэдээлнэ. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд энэ журмын 7.1 дэх заалтыг баримтлан мэдээлнэ.
- 25.10. Гадаад улсын үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нэгтгэх, хуваах, хөрвүүлэх, нэмж гаргах зэргээр гадаад улсын зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны бүрдүүлбэрт нь өөрчлөлт орох нөхцөл бүрдэх тухай бүрд Биржид урьдчилан мэдэгдэнэ.
- 25.11. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.4-д заасны дагуу хаалттай хүрээнд үнэт цаасыг худалдахаар гаргаж байгаа тохиолдолд энэ талаарх мэдээллийг Хорооны журамд заасан баримт бичгийн хамт Биржид ирүүлнэ.
- 25.12. Аймаг, нийслэлийн Засаг дарга болон олон улсын санхүүгийн байгууллагын хувьд мэдээллийн ил тод байдлыг хангахдаа Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ыг баримтална.

НАЙМ. БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

Хорин зургаадугаар зүйл. Бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс

- 26.1. Бирж нь үнэт цаас гаргагчийн өргөдлийг хянан шийдвэрлэж, үнэт цаасыг Биржийн бүртгэлд бүртгэх, үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцөлийг бүрдүүлэх,

үнэт цаасны арилжааг зохион байгуулах, бүртгэлтэй компанид үзүүлж байгаа үйлчилгээний хөлсийг тогтооно.

- 26.2. Үнэт цаас гаргагч буюу бүртгэлтэй компанид Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 26.2.1. Өргөдөл хүсэлтийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс;
 - 26.2.2. Үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлс;
 - 26.2.3. Жилийн үйлчилгээний хөлс.
- 26.3. Үнэт цаас гаргагч нь өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсийг Биржид үнэт цаас бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаас бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргахдаа буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлж, энэ тухай баримтыг өргөдөлдөө хавсаргана.
- 26.4. Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсний хэмжээ шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргахад энэ журмын хавсралт 1-д заасны дагуу байна.
- 26.5. Хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлсийг үнэт цаас гаргагч компанийн нийт бүртгүүлсэн үнэт цаасыг нийтэд санал болгох үнээр үржүүлсэн үнийн дүнгээс хавсралт 1-д заасан хэмжээгээр тооцож анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 26.6. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд энэхүү журмын хавсралт 1-д заасан хувьцааны нийт арилжаалсан үнийн дүн гэдгийг Монгол Улсын Бирж дээр арилжаалсан хувьцааны үнийн дүн гэж ойлгоно.
- 26.7. Үнэт цаас гаргагч нь нэмж үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлөх ба хөлсийг зөвхөн нэмж бүртгүүлж буй үнэт цаасны зах зээлийн үнэлгээнээс тооцно. "Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд энэхүү хөлсийг зөвхөн Монгол Улсад нэмж гаргасан үнэт цаасны зах зээлийн үнэлгээнээс тооцно."
- 26.8. Үнэт цаас гаргагч нь Биржид өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс болон үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлнө.
- 26.9. Өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгөөс тооцох бөгөөд компанийн болон Засгийн газраас гаргасан үнэт цаасны хувьд энэ журмын хавсралт 1-д заасны дагуу тус хэмжээ нь өөр өөр байна.
- 26.10. Засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн хувьд үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг Бирж болон Засгийн газар, бусад эрх бүхий байгууллага хооронд байгуулах гэрээгээр зохицуулж болно.
- 26.11. Үнэт цаас гаргагч нь жилийн үйлчилгээний хөлсийг тухайн компанийн зах зээлийн үнэлгээнээс энэ журмын хавсралт 1-д заасан хэмжээгээр тооцож, тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Биржийн дансанд шилжүүлнэ.
- 26.12. Энэ журмын 26.11-т дурдсан зах зээлийн үнэлгээг тухайн хувьцааны өнгөрсөн оны сүүлийн сарын дундаж ханшаар тооцно.
- 26.13. Үнэт цаас гаргагч нь бүртгэлээс хасагдах тохиолдолд тухайн жилийн бүртгэлтэй байх хоногт хувь тэнцүүлэн жилийн үйлчилгээний хөлсийг төлнө.
- 26.14. Үнэт цаас гаргагч нь тухайн үнэт цаасыг анх удаа Биржид бүртгүүлэх тохиолдолд тухайн оны жилийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлөгднө.

26.15. Дараах тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг 20 хүртэл хувиар хөнгөлж болно. Ингэхдээ тохиолдлуудыг давхардсан эсэхээс үл хамааран хөнгөлөлтийг эдлүүлнэ. Үүнд:

- 26.15.1. Үнэт цаас гаргагч нь I ангилалд нэмж үнэт цаас бүртгүүлэх;
- 26.15.2. Биржийн хувьцааны бүртгэлийн ангилал ахиулж бүртгүүлэх;
- 26.15.3. Биржийн “Хаалттай хувьцаат компанид зориулсан зах”-аас хувьцааны I, II ангилалд шилжин бүртгүүлэх;
- 26.15.4. Энэ журмын 2.11-т заасан этгээдийн үнэт цаасыг анх удаа бүртгэх;
- 26.15.5. Ногдол ашгаа үнэт цаасаар олгох, ажиллагсдад үнэт цаас эзэмшигүүлэх, нэгдэж нийлэх гэх мэт бодитойгоор нэмэлт хөрөнгө санхүүжилт татахгүйгээр үнэт цаасаа бүртгүүлэх;
- 26.15.6. Монгол Улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчит компани үнэт цаасаа бүртгүүлэх;
- 26.15.7. Монгол Улсын “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу шинээр хэрэгжүүлэх эсхүл одоо хэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор “Ногоон бонд” гаргаж, бүртгүүлэх.

ЕС. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

Хорин долоодугаар зүйл. Үнэт цаасыг бүртгэлээс хасах

27.1. Үнэт цаас гаргагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компани эсхүл хаалттай хувьцаат компани болох, татан буугдах, хууль болон энэхүү журамд заасан бусад тохиолдолд үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргана.

27.2. Бирж нь хууль тогтоомж, журамд заасан үндэслэл, Хорооны шийдвэр эсхүл үнэт цаас гаргагчийн гаргасан хүсэлтийн дагуу үнэт цаасыг бүхэлд нь болон хэсэгчлэн бүртгэлээс хасна.

27.3. Гадаад улсад үнэт цаас гаргагч нь анх үнэт цаас гаргасан арилжаа эрхлэх байгууллагынхаа үнэт цаасны анхдагч бүртгэлээс хасагдсан болон гадаадын зах зээл рүү хөрвүүлсэн үнэт цаасны хэмжээ нь тухайн үнэт цаас гаргагчийн Монгол Улсад бүртгэгдэж арилжаалсан нийт үнэт цаасны 80 хувьд хүрсэн нь Биржийн бүртгэлээс хасах үндэслэл болж болно.

27.4. Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гаргасантай холбоотойгоор үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Биржид хүргүүлнэ. Үүнд:

- 27.4.1. Компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;
- 27.4.2. Компанийн тухай хуулийн 23.3-т заасан шаардлагыг хангасан төсөл;
- 27.4.3. Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоосон ТУЗ-ийн шийдвэр, үнэлгээ, аудитын байгууллагын дүгнэлт;

- 27.4.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжааны төлбөр, тооцооны байгууллагуудаас гаргасан гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх тодорхойлолт;
- 27.4.5. Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсрэг саналтай байсан болон өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зуучлан зохион байгуулах брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компанийтай байгуулсан гэрээ.
- 27.5. Энэ журмын 27.4.2-т заасан төсөлд Компанийн тухай хуулийн 24-т заасан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх журам, мөн хуулийн 54-т заасан хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг тусгасан байна.
- 27.6. Энэ журмын 27.5-д заасан журмын дагуу хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардсан хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдан авсны дараа энэ тухай мэдээллийг Биржид хүргүүлнэ.
- 27.7. Үнэт цаас гаргагч нь хаалттай хувьцаат компани болон өөрчлөгдөж байгаа бол энэ журмын 27.6-д заасан ажиллагааг дууссаны дараа хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардаагүй бүх хувьцаа эзэмшигчид компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх бөгөөд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага хувьцаа эзэмшигчдийг бүртгэн авна.
- 27.8. Үнэт цаас гаргагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөгдөж байгаа бол энэ журмын 27.6-д заасан ажиллагааг дууссаны дараа хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардаагүй, компанийд хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргаагүй бол хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлнэ.
- 27.9. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 27.8-д заасан асуудлыг бүрэн хэрэгжүүлж, нотлох баримтыг Биржид ирүүлснээр үнэт цаасыг бүртгэлээс хасах ажлыг дуусгавар болгоно.
- 27.10. Хувьцааг эргүүлэн худалдах эрхийг хуульд заасан журмын дагуу бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд Бирж компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргана.
- 27.11. Бирж нь дараах тохиолдолд үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна. Үүнд:
- 27.11.1. Компанийн тухай хууль, Дампуурлын тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэр гарч, үнэт цаас гаргагч, татан буугдсан бүрэн эрхт төлөөлөгч томилсон;
- 27.11.2 Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, Биржээс тогтоосон шалгуур шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон;
- 27.11.3 Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй;
- 27.11.4 Үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй;
- 27.11.5 Өрийн хэрэгслийн хувьд төлбөр бүрэн төлөгдөж дууссан;
- 27.11.6 Хууль, журамд заасан бусад үндэслэлээр.

27.12. Үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийн хувийг Хороо болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

27.13. Бирж нь үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

АРАВ. ХАРИУЦЛАГА

Хорин наймдугаар зүйл. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 28.1. Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, үндсэн болон туслах андеррайтерийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 28.2. Үнэт цаас гаргагч нь Биржээс үзүүлэх жилийн үйлчилгээний хөлс, бүртгэлийн хөлс, бусад хөлс, хураамжийг журамд заасан хугацаанд тогтоосон хэмжээгээр төлөөгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги төлнө.
- 28.3. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрхэн мөрдөж байгаад энэхүү журмын 26.1-д заасны дагуу Биржээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагч, холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 28.4. Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагад дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь эсхүл тус тусад нь хүлээлгэнэ. Үүнд:
 - 28.4.1 Сануулах;
 - 28.4.2 Гэрээний хариуцлага ногдуулах;
 - 28.4.3 Үнэт цаасны арилжааг зогсоох;
 - 28.4.4 Үнэт цаасны ангилал бууруулж бүртгэх;
 - 28.4.5 Нэмж үнэт цаас бүртгүүлэх эрхийг хязгаарлах;
 - 28.4.6 Үнэт цаасыг бүртгэлээс хасах.
- 28.5. Үнэт цаасны арилжааг зогсоохтой холбоотой харилцааг Биржийн “Хяналт, шалгалтын журам”-аар зохицуулна. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн анхдагч бүртгэл хийлгэсэн хөрөнгийн биржээс тухайн үнэт цаас гаргагчийн гадаад улс дахь үнэт цаасны арилжааг зогсоосон боловч Монгол Улсын Бирж дээрх үнэт цаасны арилжаанд нөлөөлөл үзүүлэхээргүй бол арилжааг зогсоохгүй бөгөөд Бирж нь Монгол Улс дахь үнэт цаасны арилжаа, бүртгэл болон үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх талаар бие даасан дүгнэлт, шийдвэр гаргах эрхтэй байна.
- 28.6. Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо Бирж нь үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагын гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруутай байдлыг харгалзаж үзнэ.
- 28.7. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг тус бүртээ хариуцна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

Хорин есдүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх

29.1. Үнэт цаас гаргагч нь Биржээс үнэт цаас гаргагчтай холбоотой буюу Биржид бүртгэлтэй үнэт цаастай холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрвэл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.

Гучдугаар зүйл. Хяналт шалгалт

30.1 Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина.

~оOо~

Хавсралтууд:

Нэгдүгээр хавсралт

Хоёрдугаар хавсралт-Маягт 1

Гуравдугаар хавсралт-Маягт 2

Дөрөвдүгээр хавсралт-Маягт 3

Тавдугаар хавсралт-Маягт 4

Зургаадугаар хавсралт-Маягт 5

Долоодугаар хавсралт

Наймдугаар хавсралт

Бүртгэлтэй компанид Үзүүлэх
үйлчилгээний хэлс

Бүртгэлийн өргөдлийн маягт
/шинээр болон нэмж хувьцаа бүртгүүлэхэд/
Бүртгэлийн өргөдлийн маягт
/өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд/
Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл

Андеррайтерийн мэдэгдэл

Үнэт цаасны хадгаламжийн байгууллагад хүргүүлэх
мэдэгдэл

Бүртгэлийн гэрээ

Бүртгэлийн гэрээ / Өрийн хэрэгсэл /

~oOo~

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

1. Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс

	(төгрөгөөр)		
	I ангилаал	II ангилаал	III ангилаал
Шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх	2,000,000	2,000,000	2,000,000
Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, Бүртгэлээс хасуулах	1,500,000	1,500,000	1,500,000

2. Үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлс

2.1 Хувьцааны хувьд:

(төгрөгөөр)

	I ангилаал	II ангилаал	III ангилаал
Нийт бүртгүүлсэн үнийн дүн (33Y)-гээс тооцно.	50 тэрбум төгрөг хүртэл 0.08%	50 тэрбум төгрөг хүртэл 0.09%	0.09%
	50 тэрбум төгрөгөөс дээш болон 100 тэрбум төгрөг хүртэл 0.07%	50 тэрбум төгрөгөөс дээш болон 100 тэрбум төгрөг хүртэл 0.08%	
	100 тэрбум төгрөгөөс дээш 0.06%	100 тэрбум төгрөгөөс дээш 0.07%	
Доод хэмжээ Дээд хэмжээ	50 сая төгрөг 500 сая төгрөг	25 сая төгрөг 250 сая төгрөг	5 сая төгрөг 50 сая төгрөг
Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд нийт гаргасан хувьцаанаас бус зөвхөн Монголын хөрөнгийн биржээр анхдагч зах зээлд арилжигдах/арилжаалсан хувьцааны үнийн дүнгээс тооцох ба уг дунгийн 1% байна.			

2.2 Өрийн хэрэгслийн хувьд:

(төгрөгөөр)

Үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх үнийн дүнгээс тооцно.	5.0 тэрбум хүртэлх	5 тэрбум төгрөгөөс дээш болон 20 тэрбумтөгрөг хүртэлх	20 тэрбум төгрөгөөс дээш
---	--------------------	---	--------------------------

	0.09%	0.08%	0.06%
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн хувьд арилжаанаас татан төвлөрүүлэх үнийндүнгийн 0.025 байна. Компанийн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээ 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөгөөс багагүй, 500 сая төгрөгөөс ихгүй байна.			

3.Жилийн үйлчилгээний хөлс

(төгрөгөөр)

	I ангилаал	II ангилаал	III ангилаал
Компанийн зах зээлийн үнэлгээний 0.005%	1,200,000 төгрөгөөс багагүй, 50,000,000 төгрөгөөс ихгүй	1,200,000 төгрөгөөс багагүй, 50,000,000 төгрөгөөс ихгүй	500,000 төгрөгөөс багагүй, 25,000,000 төгрөгөөс ихгүй

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Хоёрдугаар хавсралт, Маягт 1

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Шинээр болон нэмж хувьцаа бүртгүүлэхэд/

Хэнд: “Монголын хөрөнгийн бирж”ХК,
Бүртгэлийн алба

Огноо:.....

Эрхэм Танаа,

Бид.....[Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж]

Энэхүү маягтын 2-т тусгасан үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр

1.2 Бүртгэлтэй улс,
улсын бүртгэлийн
дугаар:

1.3 Регистрийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Үүсгэн байгуулагдсан огноо:
*/Тасралтгүй үйл
ажиллагааявуулсан
жил/**

1.6 Оршин байх албан ёсны хаяг:
*/Монгол Улсад
төлөөлөгчийн газартай
бол түүний хаягийг мөн
бичнэ/*

- 1.7 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 1.8 Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:
- 1.9 Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:
/5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ/
- 1.10 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг, ТУЗ /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүд, үнэт цаас хариуцсан ажилтны талаарх мэдээлэл:
/Гүйцэтгэх удирдлага буюу удирдлагын багийн хувьд тэдний болоевсрол мэдлэг, туршлага зэргийг тодорхой бичнэ/
- 1.11 Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл:

- 1.12 Арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагчийн үнэт цаас бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл:
/Хэрэв тийм бол бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх бүртгэлтэй үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх талаарбичнэ/
- 1.13 Өмнө нь аль нэгэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байсан эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгуулагын
 нэр:
- 1.14 Өмнө нь нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий

байгууллага, түүнийг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийн дугаар, огноо:

- 1.15 Θөмөн гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

- 1.16 Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлтгаргасан эсэх:^{*}

2. Үнэт цаасны мэдээлэл:

- 2.1 Үнэт цаасны нэр:

- 2.2 Үнэт цаасны код /үсгэн ба тоон/:

/Шинээр үнэт цаас бүртгүүлэх компани нь үнэт цаасанд олгох үсгэн кодын саналаа бичнэ/

- 2.3 Үнэт цаасны төрөл:

- 2.4 Үнэт цаасны ангилал:

- 2.5 Үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн арга:^{*}

- 2.6 Хадгаламжийн бичиг хэлбэрээр бүртгүүлэх бол суурь үнэт цаасны талаарх мэдээлэл:^{*}

/Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага, бүртгэгдсэн хэмжээ, үнэ, төрөл гэх мэт мэдээллийг бичнэ/

- 2.7 Бүртгүүлэх үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн:

/Хувьцааны төрөл тус бүрээр нийтэд санал болгохоос өмнөх болон нийтэд санал болгосны дараах байдлаар бичнэ/

- 2.8 Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, үнэ, арга хэлбэр:

/Хувьцааны төрөл (энгийн ба давуу эрхийн) тус бүрээр бичнэ/

2.9 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:
/Хувьцааны төрөл (энгийн ба давуу эрхийн) тус бүрээр бичнэ/

2.10 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаарх товч мэдээлэл:

2.11 Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл:

3.1 Андеррайтерийн

оноосо
ннэр: /Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/

3.1.1. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

3.1.2. Регистрийн дугаар:

3.1.3. Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:

/Нотлох баримт хавсаргана/

3.1.4. Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

3.1.5. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.2 Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:

3.2.1. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

3.2.2. Регистерийн дугаар:

3.2.3. Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:

/Номлох баримтыг хавсаргана/

3.2.4. Оршин байх албан ёсны хаяг:

/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

3.3 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.4 Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан бол энэ тухай мэдээлэл:

/Нэр, эрхэлдэг ажил, хуулийн этгээд бол хаяг байршил, боловсрол, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал зэргийг бичнэ/

3.5 Энэхүү маягтын 3-р хэсэгт багтах зөвлөгөө өгсөн этгээдүүд нь энэ журмын маягт 3-ын дагуу мэдэгдэл гаргана.

3.6 Зохицуулалттай хуулийн этгээд үнэт цаас гаргах ажиллагаанд оролцоогүй тохиолдолд тус этгээд оролцоогүй шалтгааны талаар тайлбар гаргана.

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:

2. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

Албан тушаал:

Андеррайтерийн " К-ийн
 ТУЗ-ийн дарга " К-ийн
 Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

ТУЗ-ийн дарга
 Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

3. Овог, нэр: 4. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч Албан тушаал: Андеррайтерийн
 " К-ийн " К-ийн
 Гүйцэтгэх захирал

 Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

5. Овог, нэр: 6. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч Албан тушаал: Хуулийн зөвлөгөө
 " К-ийнүзүүлэх " К-ийн
 Ерөнхий нягтлан бодогч

 Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

Гарын үсэг:
 (Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсанажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсаногноо, цаг, минут:	Өргөдөл, хавсаргасан түүнд баримты нтоо /нүүрээр/:

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Гуравдугаар хавсралт, Маягт 2

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд/

Хэнд: “Монголын хөрөнгийн бирж” ХК,
Бүртгэлийн алба

Огноо:.....

Эрхэм Танаа,

Бид.....[Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж]

Энэхүү маягтын 2-т тусгасан үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Компанийн өрийн хэрэгслийн Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр

1.2 Бүртгэлтэй улс,
улсын бүртгэлийн
дугаар:

1.3 Регистрийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Үүсгэн байгуулагдсан огноо:
*/Тасралтгүй үйл ажиллагаа
явуулсанжил/**

1.6 Оршин байх албан ёсны хаяг:
*/Монгол Улсад
төлөөлөгчийн газартай
бол түүний хаягийг мөн
бичнэ/*

1.7 Шуудангийн болон цахим
шуудангийн хаяг, холбоо барих
утас:

- 1.8 Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:
- 1.9 Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:
/5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ/
- 1.10 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг, ТУЗ /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүд, үнэт цаас хариуцсан ажилтны талаарх мэдээлэл:
/Гүйцэтгэх удирдлага буюу удирдлагын багийн хувьд тэдний боловсрол мэдлэг, туршилага зэргийг тодорхой бичнэ/
- 1.11 Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл:
- 1.12 Арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагчийн үнэт цаас бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл:
/Хэрэв тийм бол бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх бүртгэлтэй үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх талаарбичнэ/
- 1.13 Өмнө нь аль нэгэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байсан эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр:
- 1.14 Өмнө нь нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийн дугаар, огноо:

1.15 Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

1.16 Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлтгаргасан эсэх:^{*}

2.Үнэт цаасны мэдээлэл:

2.1 Үнэт цаасны нэр:

2.2 Үнэт цаасны код /үсгэн ба тоон/:
/Шинээр үнэт цаас бүртгүүлэх компани нь үнэт цаасанд олгох үсгэн кодын саналаа бичнэ/

2.3 Үнэт цаасны төрөл:

2.4 Үнэт цаасны ангиал:

2.5 Үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн арга:^{*}

2.6 Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бол хөрвөх суурь үнэт цаасны талаарх мэдээлэл:^{*}

/Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага, бүртгэгдсэн хэмжээ, үнэ, төрөл гэх мэт мэдээллийг бичнэ/

2.7 Бүртгүүлэх үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн:

/Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол бүртгүүлэх өрийн хэрэгслийн транч тус бүрээр бичнэ /

2.8 Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, үнэ, арга хэлбэр:

2.9 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:

/Хувьцааны төрөл (энгийн ба давуу эрхийн) тус бүрээр бичнэ/

- 2.10 Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаарх товч мэдээлэл:
- 2.11 Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийнэтгээдийн мэдээлэл:

- 3.1 Андеррайтерийн оноосон нэр:
/Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/
- 3.1.1. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:
- 3.1.2. Регистрийн дугаар:
- 3.1.3. Эрх бүхий байгууллагаасолгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:
/Нотлох баримт хавсаргана/
- 3.1.4. Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/
- 3.1.5. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:
- 3.2 Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:
- 3.2.1. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:
- 3.2.2. Регистрийн дугаар:
- 3.2.3. Эрх бүхий байгууллагаасолгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:
/Нотлох баримтыг хавсаргана/
- 3.2.4. Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

3.2.5. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.3 Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан бол энэ тухай мэдээлэл:
/Нэр, эрхэлдэг ажил, хуулийн этгээд бол хаяг байршил, болоевсрол, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал зэргийг бичнэ/

3.4 Энэхүү маягтын 3-р хэсэгт багтах зөвлөгөө өгсөн этгээдүүд нь энэ журмын маягт 3-ын дагуу мэдэгдэл гаргана.

3.5 Хоёр болон түүнээс дээш тооны андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд хамтран оролцож байгаа бол шалтгааны талаар тайлбар гаргана.

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:

2. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

Албан тушаал:

Андеррайтерийн “.....”К-ийн

“.....” К-ийн

ТҮЗ-ийн дарга

ТҮЗ-ийн дарга

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр:

4. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч

Албан тушаал: Андеррайтерийн

“.....”К-ийн

“.....” К-ийн

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

.....

.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

5. Овог, нэр: 6. Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч Албан тушаал: Хуулийн зөвлөгөө
“.....”Кийнүүзүүлэх “.....” Кийн
Ерөнхий нягтлан бодогч Гүйцэтгэх захирал
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсанажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсаногноо, цаг, минут:	Өргөдөл хавсаргасан нтоо түүнд /нүүрээр/: баримты

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Огноо

I. Үнэт цаас гаргагч компанийн мэдэгдэл:

1. Үнэт цаас гаргагч[Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна:
 - 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулхтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөрбүрдүүлсэн.
 - 1.2. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой Биржийн “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”-д тусгагдсан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
 - 1.3. “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
 - 1.4. Үнэт цаас бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн өргөдөл тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд Биржид нэн даруй мэдээлнэ.
 - 1.5. Худал, ташаа мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Түүнчлэн үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
 - 2.1. Манай үнэт цаас Биржид бүртгэгдсэн нөхцөлд Биржийн “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
 - 2.2. Өргөдлийг хүлээн авч, үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржид хүргүүлнэ.
 - 2.3. Үнэт цаас гаргагч нь “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

II. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл:

1. Би[Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага] өөрийн эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж болон Хороо, Биржийн холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.
2. Дараах зүйлсийг Биржийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүйхүргүүлнэ:
 - 2.1. Биржийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг хүргүүлэх,
 - 2.2. Биржийн зүгээс “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах,
 - 2.3. Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,
3. Энэ журамд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтны шалгуур, нөхцөлийгхангаж байгааг мэдэгдэж байна.
4. Би жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бөгөөд миний албан тушаал, холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Биржиднэн даруй мэдэгдэнэ.
5. Үнэт цаас бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материалд /үнэтцаасны танилцуулга хамаарна/орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
6. Энэхүү мэдэгдлийн 3, 4-т /дээрх заалтууд/ тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

III. Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлстэй холбоотой мэдэгдэл:

1. Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс
төгрөгийг ... оны ... дугаар сарын ...—ны өдөр банкны
..... дансанд төлсөн нь үнэн болно. /Төлбөр төлсөн
баримтынхуулбарыг хавсаргах/
2. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон тохиолдолд журамд заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг Биржид төлөхөө мэдэгдэж байна.
3. Хэрэв Бирж нь өргөдөлд тусгасан үнэт цаасыг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан эсхүл анхдагч зах зээлийн арилжаа амжилтгүй болсон тохиолдолд үнэт цаас гаргагчийн төлсөн “өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс” нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
4. Хувьцаа нь бүртгэлтэй байх хугацаанд журмаар тогтоосон хувь хэмжээгээр,

заасанхугацаанд нь жилийн үйлчилгээний хөлсийг төлөхөө мэдэгдэж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр:
.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
”...К-
ийн
.....
....
.....

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” К-ийн

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

Огноо:

Бид [Андеррайтерийн байгууллага, түүнийг төлөөлж]

..... байршилтай, “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу

..... компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгоход андеррайтерийн үүрэг гүйцэтгэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

1. Компанийн үнэт цаас бүртгүүлэх өргөдлийн маягт болон Биржийн “Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу шаардлагатай бүхий л материалыг Биржид хүргүүлсэн.
2. Бид хуульд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагагааг хийж, судалсны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулснаа мэдэгдэж байна:

2.1.1. Андеррайтер нь Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцөлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материалд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, материалорхигдуулаагүй болно.

2.1.2. Үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас бүртгүүлэх өргөдөлтэй хамт хүргүүлж буй андеррайтерийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.

2.1.3. Андеррайтер нь үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.

2.1.4. Бид андеррайтерийн дүгнэлт гаргах, үнэт цаасны танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.

2.1.5. Үнэт цаас гаргагч компанийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг дангаар болон биеэ даан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд бүртгэлтэй компани болсноор хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.

2.1.6. Үнэт цаас гаргагч компани нь бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсний дараах үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

2.1.7. Үнэт цаас гаргахаар хүсэлт гаргагч, түүний үнэт цаас нь Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан хувьцааны зохих ангиллын /өрийн хэрэгслийн/ шалгуур, шаардлагыг бүрэн хангаж байна. Эсхүл шалгуур, шаардлагыг бүрэн хангахааргүй тохиолдолд журмын дагуу шалгуураас чөлөөлүүлэх буюу хөнгөлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлт гаргаж байна. (Хавсралтаар шалгуурыг хангаж буй байдлыг нарийвчлан гаргав)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал:

Андеррайтерийн

“.....” К-ийн

.....

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Андеррайтерийн

“.....” К-ийн

.....

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Зургаадугаар хавсралт, Маягт 5

**ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд:

№

Огноо:

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭ С ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:			тухай
Үндэслэл:			
Санхүүгийн хэрэгсэл:/хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/			
Үнэт цаасны нэр:			
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/			
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/			
Үнэт цаасны хэлбэр: /биет, биетбус/			
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/			
Энгийн	Тоо /ширхэг/		
	хувь %/		
	тоо		
Давуу эрхийн	/ширхэг/		
	хувь %/		
	тоо		
Төрийн эзэмшил	/ширхэг/		
	хувь %/		
	тоо		
Олон нийтийн эзэмшил	/ширхэг/		
	хувь %/		
	тоо		
Хаалттай хүрээнд	/ширхэг/		
	хувь %/		
	тоо		

Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/ Үнэт цаасны нийтүүнийн дүн: /төгрөг/				
Үнэт цаасны нөхцөл: <i>/хямдруулсан, хөрвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас өмнө эргүүлэн татах гэхмэти/</i>				
Үнэт цаасны хүү/өгөөжий нхувь хэмжээ:				
Үнэт цаасны хугацаа:				
Үнэт цаасны хүүтөлөглөх хугацаа /давтамж/				
Бусад:				

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/

/

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Долоодугаар хавсралт

Батлав: “МХБ” ХК-ийн
ийн Гүйцэтгэх захирал

Батлав: “.....”ХК-
гүйцэтгэх захирал

...../...../

...../...../

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

20... оны ... дугаар
хотсарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын Хөрөнгийн Бирж" ХК /цаашид Бирж
гэх/, түүнийг төлөөлж....., нөгөө талаас “.....”
ХК /цаашид Үнэт цаас гаргагч, хамтад нь Талууд гэх/-ийг төлөөлж

нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь Үнэт цаас гаргагч, түүний гаргасан үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасны арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх, Үнэт цаас гаргагч нь холбогдох журмын дагуу Биржид бүртгэлтэй байх хугацаанд зохих үүргийг хүлээх, үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Бирж нь бүртгэлтэй үнэт цаас гаргасан.....
гаргагчийн/...../...../ төгрөгийн нээрлэсэн
үнэтэй/...../...../ ширхэг,
нийт/...../...../ төгрөгийнхувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэнэ.
- 1.3. Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид Хороо гэх/, Биржээс баталсан журам, заавраар зохицуулна.
- 1.4. Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үнэт цаас гаргагч нь Биржийн бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

Хоёр. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 2.1. Үнэт цаас гаргагч нь Биржид дараах хөлсийг төлнө. Үүнд:

Үнэт цаасны бүртгэлийн журам

Хуудас 61

- 2.1.1. Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс. Үүнд:
- 2.1.1.1. Шинээр үнэт цаас бүртгүүлэхэд 2,000,000 (хоёр сая) төгрөг;
 - 2.1.1.2. Нэмж үнэт цаас бүртгүүлэхэд 2,000,000 (хоёр сая) төгрөг;
 - 2.1.1.3. Бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулахад 1,500,000 (таван зуун мянга) төгрөг
- 2.1.2. Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс. Үүнд:
- 2.1.2.1. Өрийн хэрэгсэл: үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгөнөөс тооцох бөгөөд 20 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнгээс 0.1 хувь, 20-50 тэрбум төгрөг хүртэлх үнийндүнгээс 0.08 хувь, 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнгээс 0.064 хувь, Ингэхдээ 2,500,000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс багагүй 500 сая төгрөгөөс ихгүй байна.
 - 2.1.2.2. **Хувьцаа:** нийт зах зээлийн үнэлгээнээс тооцох бөгөөд I ангилалд 50 тэрбум төгрөг хүртэлх бол 0.08 хувь, 50-100 тэрбум төгрөг хүртэлх бол 0.07 хувь, 100 тэрбум төгрөгөөс дээш бол 0.06 хувь, II ангилалд 50 тэрбум төгрөг хүртэлх бол 0.09 хувь, 50-100 тэрбум төгрөг хүртэлх бол 0.08 хувь, 100 тэрбум төгрөгөөс дээш бол 0.07 хувь, III ангилалд 0.09 хувь байна. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд Бирж дээр санал болгож буй хувьцааны нийт арилжаалсан үнийн дүнгийн 1 хувь байна. Ингэхдээ:
 - I ангилалд бүртгэхэд 50,000,000 /тавин сая/ төгрөгөөс багагүй, 500,000,000 /таван зуун сая/ төгрөгөөс ихгүй;
 - II ангилалд бүртгэхэд 25,000,000 /хорин таван сая/ төгрөгөөс багагүй, 250,000,000 /хоёр зуун тавин сая/ төгрөгөөс ихгүй;
 - III ангилалд бүртгэхэд 5,000,000 /таван сая/ төгрөгөөс багагүй, 50,000,000 /тавин сая/ төгрөгөөс ихгүй.
 - 2.1.3. Хувьцааны хувьд жилийн үйлчилгээний хөлс тухайн компанийн зах зээлийн үнэлгээний 0.005 хувь. Гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд Бирж дээр гаргасан үнэт цаасны зах зээлийн үнэлгээний 0.05 хувь байна. Ингэхдээ:
 - I болон II ангиллын үнэт цаасны хувьд 1,200,000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгөөс багагүй, 50,000,000 /тавин сая/ төгрөгөөс ихгүй;
 - III ангиллын үнэт цаасны хувьд 500,000 /таван зуун мянган/ төгрөгөөсбагагүй, 25,000,000 /хорин таван сая/ төгрөгөөс ихгүй.
 - 2.1.4. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөг.
 - 2.1.5. Үнэт цаас бүртгэлээс хасуулахад 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөг.

- 2.2. Гэрээний 2.1.1-т заасан төлбөрийг Биржид хүсэлт гаргахаас өмнө төлсөн байх бөгөөд буцаан олгогдохгүй.
- 2.3. Гэрээний 2.1.2-т заасан төлбөрийг анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан өдрөөс хойш ажлын З хоногийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 2.4. Гэрээний 2.1.3-т заасан төлбөрийг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Биржийн дансанд шилжүүлнэ.
- 2.5. Гэрээний 2.1.3-т заасан зах зээлийн үнэлгээг тухайн хувьцааны өнгөрсөн оны сүүлийн сарын дундаж ханшаар тооцно.
- 2.6. Үнэт цаас гаргагч нь анх удаа Биржид үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд тухайн оны жилийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлөгднө.
- 2.7. Үнэт цаас гаргагч нь бүртгэлээс хасагдах тохиолдолд тухайн жилийн бүртгэлтэй байх хоногт хувь тэнцүүлэн жилийн үйлчилгээний хөлсийг төлж болно.
- 2.8. Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсийг Биржийн Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасны дагуу тодорхой тохиолдолд 20 хүртэл хувиар хөнгөлж болно.

Гурав. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Бирж нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1. Үнэт цаасны арилжаанд хяналт тавих, тодорхой чиглэл удирдамжийн дагуушалгалт хийх;
 - 3.1.2. Компанийн тухай хуулийн 4, 7, 11, 12 дугаар бүлэгт заасан асуудлаар үнэт цаас гаргагчаас гаргасан аливаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд шалгалт хийх;
 - 3.1.3. Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас гаргуулан авах;
 - 3.1.4. Компанийн тухай хуулийн 4, 7, 11, 12, 13 дугаар бүлэгт заасан асуудлаар үнэт цаас гаргагчаас тайлбар, тодруулга шаардан авах;
 - 3.1.5. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, үнэт цаас гаргагчид мэдээллийг олон нийтэд хүргэх талаар шаардлага тавих;
 - 3.1.6. Үнэт цаас гаргагч үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн, Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд олон нийтэд мэдээлэх;
 - 3.1.7. Үнэт цаас гаргагчид үзүүлсэн үйлчилгээний хөлсийг гэрээний 2 дугаар зүйлд заасны дагуу шаардах;

- 3.1.8. Үнэт цаас гаргагчийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20, 56 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээ биелүүлэн ажиллах талаар шаардлага тавих;
 - 3.1.9. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох журам, удирдамжийн дагуу тусгай шалгалтыг хийх;
 - 3.1.10. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн тохиолдолд эрх хэмжээнийхээ хүрээнд Биржийн Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журам, Хяналт, шалгалтын журам болон бусад холбогдом журам, энэ гэрээний дагуу хариуцлага тооцох;
 - 3.1.11. Хууль, журамд заасан бусад эрх.
- 3.2. Бирж нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 3.2.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн үнэт цаасны арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх;
 - 3.2.2. Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр хөрөнгийн зах зээлтэй холбоотой асуудлаар зохих журам, шийдвэрийн хүрээнд зөвлөгөө, зааварчилгаа өгөх, сургалт, семинар зохион байгуулах;
 - 3.2.3. Үнэт цаас гаргагчтай холбоотой Биржийн журам, зааварт өөрчлөлт орсон нөхцөлд энэ талаар болон шаардлагатай мэдээллийг өөрийн цахим хуудаст байршуулах замаар үнэт цаас гаргагчид мэдэгдэх;
 - 3.2.4. Үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ, судалгааг зохих журмындаагуу үнэт цаас гаргагчийн хүсэлтээр гаргаж өгөх;
 - 3.2.5. Үнэт цаас гаргагчаас олон нийтэд мэдээлэхээр ирүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.

Дөрөв. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Үнэт цаас гаргагч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 4.1.1. Үнэт цаас бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргах;
 - 4.1.2. Хоёрдогч бүртгэл хийлгэж буй гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагч Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмаас чөлөөлөгдөх хүсэлт гаргах;
 - 4.1.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлаар Биржээс заавар, зөвлөмж авах;
 - 4.1.4. Үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Биржид санал хүсэлт гаргах, журамд заасан хугацаанд үндэслэл бүхий

хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;

- 4.1.5. Зохих нөхцөл бүрдсэн тохиолдолд бүртгэлтэй компанийд үзүүлэх үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх;
 - 4.1.6. Холбогдох дүрэм, журамд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбогдох мэдээлэл, судалгааг авах;
 - 4.1.7. Үнэт цаас гаргагчтай холбоотой Биржээс гаргасан шийдвэрийн талаар аливаа гомдлоо Хороонд гаргах.
- 4.2. Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 4.2.1. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20, 56 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг болон Биржийн Бүртгэлийн журмын 22 дугаар зүйлд заасан үүргийг бүртгэлтэй байх хугацаандаа биелүүлж ажиллах;
 - 4.2.2. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хороо, Биржийн журам, заавруудыг дагаж мөрдөх, хууль, журмын хүрээнд Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж ажиллах;
 - 4.2.3. Бирж, түүний үнэт цаасны бүртгэл болон хяналт хариуцсан ажилтнаас тавьсан шаардлагыг биелүүлэх, мэдээ, судалгаа, тайлбар, тодруулгыг гаргаж өгөх, үнэт цаас худалдах замаар хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлын хүрээнд шалгуулах;
 - 4.2.4. Өөрийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад шударга, тэгш хандах;
 - 4.2.5. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол энэ тухай тайлбар гаргаж Биржид болон олон нийтэд мэдээлэх;
 - 4.2.6. Бүртгэлтэй байх хугацаанд Биржийн Үнэт цаасны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан үнэт цаасны зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллах;
 - 4.2.7. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад болон Биржид мэдээлэл хүргэх талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.7.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулагчдад хүргэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ба Биржид мэдэгдэх;
 - 4.2.7.2. Бүртгэлтэй компаниудад холбогдох Бирж болон Хорооноос гаргасан мэдээлэл түгээхтэй холбоотой бусад журам, зааварт тусгасан мэдээллийг заасан хугацаанд цахим хэлбэрээр болон хэвлэмлээр Биржид хүргүүлэх;
 - 4.2.7.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт тусгасан анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэдээллийг

Хороо, Биржидбичгээр болон цахим хэлбэрээр хүргэх, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;

- 4.2.7.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох нийтэд тараагдаагүй мэдээллийг хөрөнгө оруулагч бусад этгээдэд нэгэн зэрэг, тэгш хүргэх;
- 4.2.7.5. Үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг дараа өдрийн арилжаанаас өмнө олон нийтэд мэдээлж, энэ тухай Биржид мэдэгдэх;
- 4.2.7.6. Олон нийтээс татсан хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг бүрэн хэрэгжүүлэх хүртэл хугацаанд түүнийг хэрэгжүүлэхэд зориулж татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн гүйцэтгэлийн тайланг хагас жил тутамд гаргаж, дараа сарын 15-ны дотор Биржид ирүүлэх;
- 4.2.8. Үнэт цаас гаргагч нь гэрээний 2 дугаар зүйлд заасан хөлсийг тогтоосон хугацаанд төлөх;
- 4.2.9. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, заавар, гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж, заасан хугацаанд хариу мэдэгдэх;
- 4.2.10. Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухай шалтгаан бүхий тайлбарыг Биржид нэн даруй бичгээр хүргүүлэх;
- 4.2.11. Гэрээний 4.2.10-д заасны дагуу тайлбар ирүүлээгүй нөхцөлд шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авна.
- 5.2. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч талууд хариуцна.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2.7.2-т заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 232.5-д заасны дагуу мэдээний төрөл бүрд 100 000 төгрөгийн анзыг Биржид төлнө.
- 5.4. Үнэт цаас гаргагч нь Биржээс үзүүлэх жилийн үйлчилгээний хөлс, буртгэлийн хөлс, бусад хөлс, хураамжийг журамд заасан хугацаанд тогтоосон хэмжээгээр төлөөгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги нэмж төлнө.
- 5.5. Үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үнэт цаасны арилжааг зогсоох болон бусад арга хэмжээтэй холбогдон хувьцаа эзэмшигч, бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.

5.6. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигт худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 9.14-р зүйлд заасны дагуу үнэт цаас гаргагч, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна.

Зургаа. БУСАД

- 6.1. Гэрээ гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Энэхүү гэрээний зарим заалт нь хуулиар хүчин төгөлдөр бусад тооцогдох бол уг заалтыг оролцуулахгүйгээр гэрээг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлүүлэхийг талуудхүлээн зөвшөөрсөн болно.
- 6.4. Талуудын хооронд гарсан маргаантай асуудлыг харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцэлд хүрч чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

Хяналт зохицуулалтын газрын захирал

/ /

Батлав:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

.....

Үнэт цаас гаргагчийг төлөөлж:

“ ” ХК-ийн

/ /

Батлав:

“ ” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

.....

/ /

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

/Өрийн хэрэгсэл/

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр №...

Улаанбаатар хот

Нэг талаас: “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид Бирж гэх), түүнийг төлөөлж Хяналт, зохицуулалтын газрын захирал

Нөгөө талаас: “.....” ХК (цаашид Үнэт цаас гаргагч гэх), түүнийг төлөөлж нар (хамтад нь Талууд гэх),

Нэг. Гэрээний нөхцөл

Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг Биржид бүртгэх, арилжих, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав. Үүнд:

- 1.1. Бирж нь Үнэт цаас гаргагчийн гаргасан / / төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий / / ширхэг компанийн өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн, өрийн хэрэгслийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохиждүрэх, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Үнэт цаас гаргагч нь арилжигдсан өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлж барагдуулна.
- 1.3. Үнэт цаас гаргагч нь Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын Нэгдүгээр Хавсралтад заасны дагуу тооцон, үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсийг анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан тухай бүр ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 1.4. Үнэт цаас гаргагч нь Биржийн “Арилжааны журам”-ын Нэгдүгээр Хавсралтад заасны дагуу өрийн хэрэгслийг анхдагч зах зээл дээр арилжаалсан үнийн дүнгээс 0.1575 хувиар тооцон, арилжааны шимтгэлийг Биржид төлнө.
- 1.5. Үнэт цаас гаргагч нь компанийн өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг түүнийг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийнөмнө Биржид албан бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлд дараах мэдээллийг хавсаргана. Үүнд:
 - 1.5.1. Өрийн хэрэгслийн нөхцөл;
 - 1.5.2. Анхдагч зах зээлийн арилжааны захиалга авах нөхцөл: захиалга авч

- эхлэх огноо, үргэлжлэх хугацаа, санал болгох арга хэлбэр г.м;
- 1.5.3. Бондын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тохиолдолд: Сүүлийн улирлын санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгад заасан үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл, өрийн хэрэгсэл гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан;
 - 1.5.4. Үнэт цаасны танилцуулгад орох нэмэлт өөрчлөлтүүд /шаардлагатай тохиолдолд/: үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, зах зээлийн орчин, санхүүгийн байдал зэрэгт орсон томоохон өөрчлөлтүүд буюу хөрөнгө оруулагчдын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц мэдээллийг тусгасан Үнэт цаасны танилцуулгын нэмэлт хавсралт.
- 1.6. Үнэт цаас гаргагч нь дараах мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 1-3 өдрийн дотор Биржид ирүүлнэ. Үүнд:
- 1.6.1. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлт хийгдсэн тухай;
 - 1.6.2. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болох эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг зохих хууль, дүрэм, журмын дагуу холбогдох этгээдэд бүртгүүлсэн, тусгаарлуулсан тухай;
 - 1.6.3. Төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тухай, үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
 - 1.6.4. Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (өрийн хэрэгслийн нөхцөл, төлбөрийн хуваарь, нийтэд санал болгох хугацаа өөрчлөгдөх г.м)-ийн талаарх мэдээлэл;
 - 1.6.5. Үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагчдын шийдвэр, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллүүд.
- 1.7. Бирж нь Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авхуулахаар холбогдох эрх бүхий байгууллагуудад хандах эрхтэй.
- 1.8. Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, заавар, энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс аливаа этгээдэд учирсан хохирлыг Үнэт цаас гаргагч, түүний холбогдох албан тушаалтан бүрэн хариуцна.

Хоёр. Хариуцлага

2.1. Үнэт цаас гаргагч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу аргахэмжээ авна.

2.2. Андеррайтер болон үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.

Гурав. Маргаан шийдвэрлэх

3.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргаан, гомдлын шаардлага зэргийг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

3.2. Хэрэв талууд гэрээтэй холбогдох маргааныг энэхүү гэрээний 3.1-т зааснаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

4.2. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчлэх ба өрийн хэрэгслийн төлбөр бүрэн төлөгдж, гэрээний үүргийн биелэлтийг хангаснаар дуусгавар болно.

4.3. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

Хяналт зохицуулалтын газрын
захирал

Үнэт цаас гаргагчийг

төлөөлж: “.....” ХК-ийн

.....

~oOo~